

Улаанбаатарт: ӨНӨӨДӨР



Өдөр +20
Шөнө +10

УЛС ТӨР

ЗАСГИЙН ГАЗАР ЮУ ХЭЛЭЛЦЭВ

II нүүрт

СПОРТ

Б.МӨНГӨНЧИМЭГ: ЯМАР Ч
ТОМ БӨХТЭЙ ӨӨРИЙНХӨӨРӨӨ
БАРИЛДААД, ЯЛНА Л ГЭЖ БОЛДДОГ

V нүүрт

Дугаарын 60 мөр


ҮЗЭЛ БОДОЛ

Анхдагч нь анагаах боллоо г.ГАНЧИМЭГ

САЙДЫН ТООГ НЭМЭХЭЭР ЯРЬЖ ЭХЭЛЛЭЭ

Нийслэл хот маань хүн амын хэт төвлөрлөөсөө болоод үүрэх ачаа нь улам хүндэрсээр байна. Замын түгжрэл, цэцэрлэг, сургуулийн хүртээмжгүй байдлын гол шалтгаан нь ерөөсөө л энэ. Үүнийг дээр дооргүй мэдэж байгаа ч дорвитойхон хийсэн ажилгүй он цагийг элээсээр л өдийг хүрлээ. Үе үеийн засаг, төрийн удирдлагууд солигдохдоо “Их, дээд сургуулиудыг хотоос гаргана” эсвэл “Томоохон захуудыг нүүлгэнэ” гэх мэтээр ярьсаар ирсэн. Хамгийн сүүлийн жишээ гэхэд, Авто худалдааны төвийг хотоос нүүлгэнэ гэдэг шийдвэр. Харин автомашины худалдаа эрхлэгчид үүнийг эсэргүүцэж, “Нүүхгүй, үлдэнэ ээ” л гэж эцсээ хүртэл гүрийсээр байгаа.

Үргэлжлэл нь III нүүрт



Б.ӨНӨРТӨГТОХ

“Эр хүний дотор эмээлтэй хазаартай морь багтдаг гэгчээр М.Энхболдын удирдсан танхимд суугаа МАН-ын 65 гишүүн бүгдээрээ л сайд болох хүсэл тээж байгаа. Дур эзнээ голохгүйгээс хойш нэг жил ч болтугай сайдын сэнтийд заларч, намтартаа нэг хуудас нэмэх гэж зүтгэнэ. Тэгэхээр, шинэ байгуулагдах Засгийн газар нэг жилийн л настай байх болов уу. Дөрвөн жилийн хугацаанд дөрвөн удаа Засгийн газар байгуулсан АН-ын рекордыг тун удахгүй Ардын нам эвдэнэ. Харж л байгаарай” хэмээн мэдээлэл дунд тун ойрхон байдаг улстөрч ярьж суух юм. Түүний дүгнэлт ч нэг их хол зөрөхгүй нь. Хэдийгээр өөр нам байгуулж өрх тусгаарласан ч МАН дотор найз нөхөдтэй учраас энэ намд өрнөж буй ил, далд тулаан, эрх ашгийн төлөөх зөрчлийг чих тавьж суугаа нь дамжиггүй.

Үргэлжлэл нь III нүүрт

ОРЧЛОН ХОРООЛОЛ

10-р ээлж

БОРЛУУЛАЛТЫН АЛБА

8810-4107

8807-1398





ХААН банк					Худалгаа хөгжлийн банк						
	Авах	Зарах		Авах	Зарах		Авах	Зарах		Авах	Зарах
АМ.ДОЛЛАР	2450.00	2464.00	ФУНТ	3220.00	3299.00	АМ.ДОЛЛАР	2446.00	2462.00	ФУНТ	3218.00	3304.00
ЕВРО	2905.00	2966.00	РУБЛЬ	41.70	43.60	ЕВРО	2909.00	2304.00	РУБЛЬ	41.70	44.10
ИЕН	22.09	22.58	ЮАНЬ	373.00	378.50	ИЕН	21.97	22.62	ЮАНЬ	374.00	378.40

Өчигдрийн 19.00 цагийн байдлаар

ΥΛΣ ΤΘΡ

МЭДЭЭЛЭЛ

Ногоон зээлийн сан байгуулна ГЭВ

Банкууд ногоон хөгжлийг дэмжих тогтвортой санхүүжилтийг байх ёстой гэдэг зарчмыг одоогоос хэдэн жилийн өмнө арьх эхэлсэн. БОАЖЯ-ны санаачилгаар энэхүү яриаг ажил хэрэг болгох үүднээс “Ногоон эзэлийн сан”-г байгуулах бэлтгэл ажлыг хангаад байгаа юм. Улмаар байгальд ээлтэй технологи хохирон бүтээгчид болон хэрэглэх хүсэлтэй иргэдийг дэмжих зорилготой энэхүү санг төр, хувийн хэвшлийн түншлэл дээр тулгуурлан олон улсын сангуудаас хөрөнгө татах замаар эхлүүлэхээр эзэхж байгаа аж. Энэ хүрээнд БОАЖЯ, Монголын банкны холбоотой хамтран “Монгол Улсын тогтвортой санхүүжилтийн форум 2017” чуулга уулзалтыг зохион байгууллаа. Чуулганы үеэр БОАЖ-ын сайд Д.Оюунхоролын урилгаар Монгол Улсад айчлалж буй НҮБ-ын Байгаль орчны хөтөлбөрийн захирал Эрик Солхейм Монгол Улсын агаар, орчны бохирдлыг эсрэг гаргаж буй санал, санаачилгыг тайшаагаад, цаашид НҮБ болон түүний гишүүн байгууллагууд дэмжиж ажиллахаа илэрхийлжээ. БОАЖ-ын сайд Д.Оюунхорол чуулганыг нээж үгэндээ “Манай улс НҮБ-ын Ногоон эдийн засгийн төлөөх түншлэлд хамгийн анх нэгдэж, энэ санаачилгын үр өгөөжийг хүртэж эхэлсэн орон. Ногоон эдийн засгийн төлөөх түншлэл нь экосистемийн тэнцвэртэй байдал, эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах замаар нийгмийн хөгжлийг тэтгэх. Монгол Улсын Засгийн газрын бодлогыг тууштай дэмжиж ирсэн билээ. Энэ түншлэлийн хүрээнд тогтвортой хөгжлийн эрхзүйн шинэчлэл, бодлогын судалгааг хийж, ногоон барилгын үндэс суурийг тавьж, мэдлэг түгээх, хүний нөөцийг чадваржуулах чиглэлээр олон ажил хийж гүйцэтгээд байна” гэв.

ЗАСГИЙН ГАЗАР

ЗАСГИЙН ГАЗАР ЮУ ХЭЛЭЛЦЭВ

Б.ТОГТОХ

Долоо хоног бүрийн
лхагва гарагт Засгийн газар
ээлжит хуралдаанаа хийдэг
уламжлалтай. Уламжлал
ёсоор өнгөрөгч лхагва гарагт
Ж.Эрдэнэбатын тэргүүлж буй
Засгийн газар хуралдсан юм.
Өнгөрөгч долоо хоногт Засгийн
газрыг огцруулсан учраас энэ
уадад тэд үүрэг гүйцэтгэгч
гэсэн албан тушаалтайгаар
асуудлаа хэлэлцдэг. Лхагва
гарагийн хуралдаанаар хэд
хэдэн асуудал хэлэлцсэний
хамгийн чухал нь Ноён уул,
Тост, Тосон бумбын нуруу
орчмын тусгай зөвшөөрлийг
цуцлах шийдвэр байлаа. Олон
жилийн турш, нутгийн иргэд,
уул уурхайн компанийн эздийн
дунд маргаан дагуулж байсан
асуудлыг нэг мөр шийдэж
өгсөн нь яах аргагүй сайн
мэдээ байсан юм. Засгийн
газраас гаргасан шийдвэрээр
бол Булган аймгийн Тэшиг
сумын нутагт орших Дархан
цаазат газрын хилийн зааг,
Сэлэнгэ аймгийн Мандал
сумын нутагт орших Ноён уул
орчмын байгалийн нөөц газрын
хилийн зааг, Төв аймгийн
Борнуур, Батсүмбэр сумын
нутаг дэвсгэрт орших Ноён
уул орчмын дурсгалт газрын
хилийн зааг, Өмнөговь аймгийн
Гурвантэс сумын нутагт орших
Тост, Тосон бумбын нурууны
байгалийн нөөц газрын хилийн
заагт багтсан аж ахуйн нэгжийн
тусгай зөвшөөрлийг цуцлахыг
Ашигт мөлтмөл, газрын тосны
газрын дарга Б.Баатарцогтод
даалгав. Ингэснээр нэр бүхий
аж ахуйн нэгжүүдийн 14
зөвшөөрлийг хүчингүй болох
юм байна. Эдгээр газрын
тусгай зөвшөөрлийг цуцлах
шийдвэрийг зүгээр ч сэтгэлийн
хөөрлөөр гаргачихаагүй.
Өөрөөр хэлбэл, Уул уурхайн
яамны сайдын тушаалаар
байгуулагдсан ажлын хэсэг бүх

галаар шалгалт явуулж, хөрөнгө оруулалт, зардлын хэмжээг зэргийг судалж тогтоосон учраас цуцлах шийдвэрт хүрчээ. Хуралдааны дараагийн хэлэлцсэн сэдв нь цагдаагийн албан хаагчдын тэтгэмж, нөхөн олговрын асуудал байжээ. Тодруулбал, цагдаагийн албан хаагч албан үүргээ гүйцэтгэж, явахдаа эрүүл мэндээрээ хохирч, гэмтэл авсан бол сувилагд хэрхэн амрах, ямар эмнэлэгт үзүүлэх, мөнгийн тэтгэмжийг ямар байдлаар олгохыг шийдвэрлэсэн аж. Ингэснээр хөдөлмөрийн чадвараа 40-49 хүртэл хувиар алдсан бол хөдөлмөрийн хөрсний доод хэмжээг 30 дахин, чадвараа 50-69 хувиар алдсан бол хөдөлмөрийн хөрсний доод хэмжээг 60 дахин, хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан буюу 70-аас дээш хувь бол хөдөлмөрийн хөрсний доод хэмжээг 90

дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээгээр тооцож нөхөх олговор, тусламж олгох юм. Мөн улсын болон харьяа дүүргийн эмнэлэг үнэ төлбөргүй эмчлэх, сэргээн засах сувилалд очих, буцах зардлыг нш жилд нөг удаа олгож байхаар шийдэлд хүрсэн байна. Монгол Улсын нийслэлд шүлхий өвчин гарсан гэх асуудал нийгмийн хамгийн анхаарал татсан сэдэв болоод буй. Тэгвэл энэ асуудлыг ч Засгийн газар анхаарлын гадна орхисонгүй. Улмаар, ХХААХУ-ийн сайдын үүрэг гүйцэтгэгч П.Сэргэлэнгээс цаг үеийн мэдээлэл авч, сайдын батлагдсан төсвөөс шүлхий, мялзан өвчний вакцин авах чиглэл өгсөн байна. Шууд үйлдвэрлэгчтэй гэрээ хийж, ямар нэг шат дамжлага дамжуулахгүйгээр вакцин авч, шүлхий өвчин гарсан голомтод бусуудад хүргүүлэхээр болжээ.

Өнөөдрийн байдлаар Сүхбаатар
аймгийн Мөнххаан, Асгат,
Баруун-Урт, Товь аймгийн
Сэргэлэн, Дундговь аймгийн
Гурвансайхан, Өлзийт,
Сайнцагаан, Хэнтий аймгийн
Баянхутаг, Мөрөн сум болон
Сонгинохайрхан, Хан-Уул
дүүдүүрт хорио цээрийн дэглэм
тогтоогоод байна. Хуралдааны
дараагийн хэлэлцсэн чухал
асуудал нь хоёр хөршийн
харицлаатай холбоотой
асуудал байсан аж. Тодруулбал,
Монгол, ОХУ, БНХАУ-ын
төрийн тэргүүн нар “Монгол-
Орос-Хятадын эдийн засгийн
коридор байгуулах хөтөлбөр”
баталж энэ хүрээнд хот
байгуулалт, дэд бүтэц, эрчим
хүч, хүрээлэн буй орчин, аялал
жуулчлал, хөдөө аж ахуй зэрэг
салбарт 32 төсөл хэрэгжүүлэх
болсон. Дээрх хөтөлбөрийг
Монголын талаас хэрэгжүүлэгч
гол байгууллага нь Гадаад

харилцааны яам бөгөөд Хөрөнгө оруулалтын судалгааны төв байгууллахаар заасан байна. Төв нь төслүүдийн Техник, эдийн засгийн урьдчилсан тооцооллын хийх, төсөл хэрэгжүүлэхэд шаардлагатай гурван улсын дүрэм, журмыг уялдуулах талаар судалж зөвлөмж, аргачлал боловсруулах, дэд бүтэц, боомт, чөлөөт бүс, хот байгуулалттай холбоотой төслүүдийн байгаль орчны нөлөөллийн үнэлгээг олон улсын стандарт, Монгол Улсын холбогдох хууль, тогтоомжид нийцүүлэн бие даан боловсруулах зэрэг чиглэлээр ажиллах юм. Төвийн дүрэм, бүтцийг батлан мөрдүүлж, бүртгүүлэх, яамд, агентлаг, бусад шаардлагатай байгууллагаас мэргэжлийн хүн авч түр хугацаагаар ажиллуулахыг Гадаад харилцааны сайдын үүрэг гүйцэтгэгч Ц.Мөнх-Оргилд даалгажээ.

ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ

“Ерөнхийлөгчийн хууль санаачлах
эрхийг хязгаарлаж болохгүй”

Б.ТОГТОХ

МУИС-ийн Эрдмийн ордонд өчигдөр Үндсэн хуульд өөрчлөлт оруулах асуудлаар эрдэмтэн, судлаачид хэлэлцүүлэг өрнүүллээ. Үндсэн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах асуудал жил жилийн парламентын ярианы сэдэв болдог ч шийдэлд хүрч байсан нь ховорхон. Харин энэ удаагийн парламент асуудлыг шуурхай хэлэлцэж, Үндсэн хуулийг өөрчлөх эсэх асуудлаар салбар бүрийн төлөөллийн байр суурийг сонсч буй юм. Тэр ч байтугай иргэдээс 239 мянган санал авч, санал нэг бүрийг цахим хэлбэрт оруулан мэдээллийн сан бүрдүүлж буйгаа мэдэгдсэн билээ. Харин өчигдөр Үндсэн хуулийг баталж байсан болон монголын хуульзүйн салбарт олгойл цохиж буй эрдэмтэн судлаачид энэ асуудлын хүрээнд хэлэлцүүлэг өрнүүлж, байр сууриа илэрхийлээ. Тухайлбал, Шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн академич С.Нарангэрэл, Ерөнхий сайд асан, доктор, профессор Д.Бямбасүрэн нарын эрдэмтэд Үндсэн хуулийг өөрчлөх асуудлаар саналаа хэлэв. С.Нарангэрэл академич Үндсэн хуульд ерөнхий байдлаар өөрчлөлт оруулах шаардлагагүй гэв. Мөн үндсэн чиг үүргийн яам тав байх, Ерөнхийлөгчийн хууль санаачлах эрхийг хасна гэсэн нь Монгол төрийн тэргүүний байхгүй болгох, цаашлаад Үндсэн хуулийн зөрчил рүү явсан санал хэмээн эсэргүүцэв. Тэрбээр, “Ерөнхийлөгчийн хууль санаачлах эрхийг хязгаарлах заалт оруулсан байна. Ингэж огт болохгүй. Яагаад гэвээр УИХ-ын чуулган жилд хоёр удаа завсарладаг. Чуулган завсарлах хугацаанд онц байдл зарлах, дайны байдл зарлах шаардлага гарвал Ерөнхийлөгч хугацаа алдахгүй шийдэх боломжийг хязгаарлаж байна. Өөрөөр хэлбэл, УИХ ирцээ бүрдүүлж, хуулийн төслөө өргөн барих гэсээр байтал хугацаа алдах аюултай. Үүнээс гадна Ерөнхийлөгч өөрийн бүрэн эрхийн хүрээнд Засгийн газарт чиглэл өгөх эрхийг хүчингүй болгох заалт оруулж байгаа юм байна. Монгол Улсын Ерөнхийлөгч гадаад улсад Монгол Улсаа төлөөлөх, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг тэргүүлэх, цэргийн хэсэгчилсэн дайчилгаа, онц байдл зарлах бүрэн эрхтэй. Энэхүү онцгой бүрэн эрхийнхээ хүрээнд Засгийн газарт чиглэл өгөхөөс өөр аргагүй. Цаашид Үндсэн хуулийн дотоодтой зөрчилдөнө. Жишээ нь Үндсэн хуульд Монгол Улсын Ерөнхийлөгч Монгол Улсын төрийн тэргүүн байна гэж заасан байдаг. Гэтэл Монгол Улсын төрийн тэргүүн гэдэг шинжийг байхгүй болгох гээд байна. Ингээд ирэхээр дээр хэлсэн Үндсэн хуулийн зөрчил явагдана” гэв. Харин Ерөнхий сайд асан Д.Бямбасүрэнгийн тухайд Үндсэн хуулийг өөрчлөх нэрийдлээр төрийн эргэлт хийхээр санаархаж байна хэмээн мэдэгдэв. Засгийн эрх мэдлийг намаар халхавчилсан олигарх бүлэглэл, тэдний эзэд авч байгаа нь өнөөдрийн бодит байдал. Гэтэл үүнийг Үндсэн хуульд өөрчлөлт оруулснаар улам бүр баталгаажуулах гэж байгаа учраас нэмэлт өөрчлөлтийг дэмжихгүй гэдгээ ил тод хэллээ. Салбарын эрдэмтэн судлаачдын дийлэнх нь энэ удаагийн нэмэлт өөрчлөлт иргэдийн хүлээж буй өөрчлөлтийг бус бүлэглэл, хэсэг бүлгийн эрх мэдлийг батжуулах гэсэн явуулгүй үйлдэл хэмээн дэмжихгүй гэдгээ хэлсэн юм.

ШАР **МЭДЭЭ**

Ү.Хүрэлсүхэд хоосон авдар өгнө
ГЭНЭ ҮҮ

Б.ЭРХЭС

“Мэргэжлийн” гэх тодотго
Засгийн газар өнгөрсөн нэг жи-
хугацаанд гаднаас зээл тусла-
вч, цалингаа тавьж байлаа.
түмнийхээ халаасыг сэгсэрч, до-
төрлийн татвараар дарамталж
хоногийг өнгөрүүлж байв. Г
Ж.Эрдэнэбатын Засгийн г
огцронгуут өнөөх зээл тусламж
хамт зогссон нь өчигдрөөс тодо-
болж эхлэв. Тодруулбал, “Өргөтг
санхүүжилтийнхөтөлбөр”хэрэгжү
байсан Валютын сангийнхан ч
Засгийн газар бүрдэх хүртэл дараа-
санхүүжилтээ зогсоохоо мэдэг-
жн билээ. Эргэж нягталж яри-
зүйл байгаа хэмээсэн ч цаад үг
“Та нар бидний шаардлагыг хү-
в. Бидний заасан замгаар явахгүй
өөр яриа байхгүй шүү” гэсэн сану-
гдэдийг учир мэдэх үлстөрчид ч
байх юм. Тэгэхээр шинэ томилго
Ерөнхий сайд, Сангийн сайд
Валютын сангийн “шар ах” нары-
үгээр явахгүй бол, дараагийн Зас-
газар хоосон авдар хүлээж ава-
гэсэн үг. Тэгвэл МАН-ын са-
ордонд “У.Хүрэлсүхэд Ерөн-
сайдйг нь өг. Өртэй, мөнгөгүй

орныг яаж хөгжүүлэхийг нь харья. Хоосон авдар бөгөөд цөөр цаадаг чинь жил болгодог л өөрөө өгье гээд хүрээд ирнэ. Тэр цагт улс төрөөс ч, намаас ч бүрмөсөн зайлуулж болно" гэсэн яриа гараад амжсан сурагтай. УХүрэлсүх ч бай, хэн ч байсан ер нь бол хоосон авдар хүлээж авах нь тодорхой. Том төслүүд хөдөлгөж, зээл тусламжаа зогсоохгүй үргэлжлүүлэх чадвартай Ерөнхий сайд тавихгүй бол 2020 онд МАН-ынхан бүгдээрээ улсаа дампууруулсан хэрэгт унах нь тодорхой билээ. Гитар барьсан залуутайгаа хамт түүхийн тавцангаас аригчдахгүйн тулд МАН-ын 65 бүгдээрээ л хөдлөхөөр аргагүй. Хэн нэгн намаас зайлуулахын тулд төс айдын суудлаар тоглож, джилд дөрвөн өөр Засгийн байгууллага гээд МАН-ын нэгсэргээ нь юу л бол. Эсрэгээрээ чинь хувь заяаг давтахтай вий дээ.

МЭДЭЭЛЭЛ

Ц.Сандуй энэ сарын 22-нд ажлаа өгнө

НИТХ дахь МАН-ын бүлгийн нэр бүхий гишүүд 60 тэрбумын асуудалд нэр холбогдсон Ц.Сандуйг огцруулахыг шаардсан албан бичгийг наймдугаар сарын 17-ны өдөр НИТХ-д өргөн барьсан билээ. Мөн сарын 31-нд НИТХ дахь МАН-ын бүлгийн хуралдааны үеэр Ц.Сандуй НИТХ-ын дарга болон Нийслэлийн МАН-

ын хорооны даргын албан тушаалаа тус тус хүлээлгэн өгөх өргөдлөө өгсөн байдаг. Гэвч өнөөдрийг хүртэл албан тушаалаа хүлээлгэн өгөх эсэх нь тодорхойгүй байв. Тэгвэл Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тов албан ёсоор гарчээ. Энэ сарын 22-нд буюу ирэх долоо хоногийн баасан гарцаг ээлжит хурлаар

НИТХ-ын дарга Ц.Сандуйг
огцруулах эсэхийг шийдэх юм
байна. Харин дараагийн дарга
хэн байх вэ гэдгийг МАН-
ын Бага хурлаар шийдэх аж.
Эх сурвалжийн мэдээллээр,
НИТХ-ын даргад МАН-ын
Ерөнхий нарийн бичгийн дарга
Д.Амарбаясгалангийн нэр
яригдаж буй юм.

ҮЗЭЛ БОДОЛ

Үргэлжлэл.
Түрүүч нь I нүүрт

“Мэргэжлийн” Засгийн газар огцорсноос хойш долоо хоногийн хугацаа өнгөрчихөөд байхад дараагийн сайд хэн байх нь нэг мөр тодорсонгүй. Хаа нэгхэн фракциуд нь нууц уулзалт хийж, Ерөнхий сайдын тохироог ярихаас бусдаар яамдын сайд хэн байх вэ гэсэн ерөнхий дүр зураг энэ өдрүүдэд гарсангүй. Цусгүй тулаан тун ч нууцхан өрнөж байна, энэ намд. Чуулган завсарлаж, Төрийн ордон ойрын өдрүүдэд ажин түжин байгаа. Гэвч МАН-ын саарал ордон эсрэгээрээ хоёрдугаар ээлжийн хоолонд орох гэсэн зангиатай залуусаар дүүрчээ. Мөрөөдлөө тэд ажил хэрэг болгохоор яарч яваа нь тэр. Мөнгөө барьчихаад очерлож

Бас л бярдаж чадаж байгаа юм шүү. Тиймдээ ч Тусгаар тогтнолын ордонд дараагийн Засгийн газрын бүтэц шинээр зурагдаж буй яриа чих дэлсэх нь тэр. Сураг сонсох нь ээ, 2012 онд Н.Алтанхуягийн Засгийн газрын үед яригдаж байсан 19 яам, 21 сайдтай байхаар бүтцээ зурж байгаа гэнэ. Өнгөрсөн нэг жилийн хугацаанд явж ирсэн яамдын бүтцийг задалж, зарим яамдуудыг хоёр хуваах яриа хэлцэл эрчимтэй явж байгааг

...Мөн Соёл, урлаг, спорт хариуцсан сайдад Н.Учралын нэр бичигдсэн байгааг эх сурвалж дуулгалаа. Шагналаа хүлээсэн улстөрчдийнхөө амыг таглахын тулд сайдын суудал шинээр бэлтгэж суугаа МАН-ынхнаас дэд сайдын суудлаа байхгүй болгооч гэх мэт биелэх боломжгүй хүсэлт илгээх нь амны гарз биз ээ. Дэмий цаг гарзадсан хэрэг...

дарамт учруулж байгаа сураг дуулдав. Мөн зарим яамдын сайдын нэрс эхнээсээ дуулдаж эхлэв. Боловсрол, шинжлэх ухааны сайдад Я.Содбаатарын нэр бичигдсэн бол Гадаад харилцааны сайдаар Г.Занданшатар, Хуульзүйн сайдад Ш.Раднаасэд,

Батлан хамгаалах сайдад Ж.Энхбаяр, Эрүүл мэндийн сайдад Д.Сарангэрэл нарын нэр зурагдчихсан байгаа аж. МАН-ын бүлгийн дарга Д.Хаянхярваа ч сайд болчих хүсэл тээн анд нөхөд рүүгээ утас цохиж яваа аж. Өмнө хэлсэнчлэн, албан тушаалын тохироо хэн хэдийг төлөхөөс шалтгаалдаг бичигдээгүй хууль ёсоор ирэх өдрүүдэд энэ нэрс өөрчлөгдөх магадлал ч өндөр. Мөн Соёл, урлаг, спорт хариуцсан сайдад Н.Учралын нэр бичигдсэн байгааг эх сурвалж дуулгалаа. Шагналаа хүлээсэн улстөрчдийнхөө амыг таглахын тулд сайдын суудал шинээр бэлтгэж суугаа МАН-ынхнаас дэд сайдын суудлаа байхгүй болгооч гэх мэт биелэх боломжгүй хүсэлт илгээх нь амны гарз биз ээ. Дэмий цаг гарзадсан хэрэг. Хоёрдугаар ээлжинд хоолонд орохоор очерлох мөнгөтэй “бацаанууд”-ын мөрөөдөлд хязгаар байхгүй бололтой. Ер нь байсхийгээд л салгаж нийлүүлж, мөнгөтэй улстөрчид зориулж сайдын суудал бэлтгэж байхаар яамны тоогнээлттэйболгочихволяадаг юм бэ, улстөрчид өө. Монголоор дүүрэн байгаа салбар бүрийг хариуцсан сайдтай болчихвол албан тушаалд очих гэж мөнгө барьж очерлохгүй амар болно доо. Боловсон хүчний асар их нөөцтэй МАН-д бол сайд хийчих хүн хэдэн мянгаараа олдох байлгүй. Дугаар хорооны Доржийн үс засалтыг хариуцсан сайд. Дугаар байрны Дулмаагийн дотуур хувцасны асуудал эрхэлсэн сайд гээд л... Гоё юм биш үү, МАН-ынхаан.

САЙДЫН ТООГ НЭМЭХЭЭР ЯРЬЖ ЭХЭЛЛЭЭ

суугаа нь ч дамжиггүй. Албан тушаал болгон заавал дэмжлэгтэй явдаг хойно ах нарынхаа үүдийг сахисан “хурган” дарга нарын санаархлыг буруутгах аргагүй биз ээ. МАН өнгөрөгч лхагва гаргат Удирдах зөвлөлөө хуралдуулан Бага хурлаа энэ сарын 25-нд гэж зарласан. Дараагийн намын дарга хэн байхаас хамаарч Ерөнхий сайдын суудал эзэнтэй болно. Танхимаа хэнээр бүрдүүлэх эрх нь Ерөнхий сайдын мэдэлд байгаа ч огцруулах товчлуурын шагналаа горьдсон 31 улстөрчийн эрх ашгийг ч бас мартах учиргүй. Мөнгө төлсөн бизнесмэнүүд хөгжмөө захиалахаа мэдэгдэж, өөрийн хүнээ сайдын суудалд суулгахаар бэлдэж эхэлсэн яриа ч чих дэлсч байна. Мэргэжлийн Засгийн газрыг түлхэн унагахад үнэтэй кнопоо харамгүй хайрласан АН-ын найман гишүүн ч амласнаа хэзээ өгөхийг анаж суугаа юм билээ. Хэлэлцээ ёсоор бол жинжиг албан тушаалуудыг АН-д өгнө хэмээн амласан гэх. Ингээд бодоод үзэхээр энэ намд 16 сайдын суудал арай л жулдаад байгаа биз. Гурван сая хүнийхээ асуудлыг тус тусад нь хариуцах 30 яам байгуулсан ч чадах л хүмүүс. Албан тушаалд хүрч байвал ахиад 20 яам байгуулсан ч ер нь яадаг юм хэмээн бардаж суугаа гэнэ лээ, МАНайхан.

ХЭН ЮУ ХЭЛЭВ

Э.ТУУЛ

Өнгөрсөн долоо хоногт улс төрийн хүрээнд халуухан үйл явдал өрнөсөн. МАН-ын байгуулсан “Мэргэжлийн” гэх тодотголтой Засгийн газар 404 хоногийн дараа намын гишүүдийнхээ тавьсан дэзээнд унаж, Монгол Улсын Ерөнхийлөгчийн оффшорчдод үзүүлсэн 49 хоногийн өршөөлийн хугацаа дуусч, МАН-ын Удирдах зөвлөл хуралдаж, бага хурлынхаа товыг зарласан гээд олон асуудал өрнөв. Ингээд зарим хүмүүсийн байр суурийг тоймлон хүргэе.

Г.Занданшатар:
Ерөнхий сайдаа томилж чадахгүй бол УИХ тарах ёстой

/УИХ-ын гишүүн/

УИХ дараагийн Засгийн газрыг 30 хоногийн дотор байгуулах үүрэг хүлээж буй. Тиймээс ирэх аравдугаар сарын 08-наар Засгийн газрыг байгуулах хуулийн хугацаа дуусна гэсэн үг юм. Энэ талаар УИХ-ын гишүүн Г.Занданшатар байр сууриа илэрхийлжээ. Тэрбээр “Засгийн газрын тухай хуульд Ерөнхий сайдыг огцруулсан, чөлөөлснөөс хойш 30 хоногийн дотор нөхөн томилоо гэсэн тодорхой заалт бий. Бид хуулиа биелүүлэх ёстой. Монгол Улсын Үндсэн хуулийн 22.2 дугаар зүйлд Үндсэн хуульд өөрөөр заагаагүй бол Монгол Улсын Ерөнхий сайдыг томилох санхьг УИХ-д өргөн мэдүүлснээс хойш дөчин тав хоногийн дотор Улсын Их Хурал хэлэлцэн шийдвэрлэж чадаагүй бол өөрөө тарах буюу эсхүл Монгол Улсын Ерөнхийлөгч Улсын Их Хурлыг тараах тухай шийдвэр гаргана гэдэг заалт бий. Тэгэхээр бүх шат дараалал хуулийн хугацаатай. Олон улсад хоёр жишиг байдаг. Германы Үндсэн хуульд дараагийн Ерөнхий сайдаа тодруулчихаад, өмнөх сайдыг огцруулах заалттай. Нөгөө жишиг нь огцруулчихаад тодорхой хугацааны дараа

Засгийн газраа бүрдүүлдэг тогтолцоо байна. Өмнө нь манайх Ц.Элбэгдоржийн Засгийн газрыг огцруулчихаад үүрэг гүйцэтгэгчээр найман сар явуулж байсан. Харин одоо бол Үндсэн хуулийн заалтаар бид 30 хоногийн дараагийн Ерөнхий сайдаа тодруулах ёстой. МАН-ын мөрийн хөтөлбөрт мэргэжлийн Засгийн газар байгуулна гэж амлалт өгсөн. Энэ амлалтаа биелүүлнэ. Үндсэн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн төсөлд Засгийн газрын 1/3 буюу үндсэн чиг үүргийн яамдаас бусад нь давхар алба хашиж болохгүй гэж оруулаад байна” хэмээжээ.

О.Баасанхүү: Засгийн газрыг огцруулах үндэслэл нь буруу байсан

/УИХ-ын гишүүн/

УИХ-д суудалтай МАХН-ын цор ганц гишүүн О.Баасанхүү Засгийн газрыг огцруулах хуралд биечлэн байгаагүй боловч байр сууриа мөн илэрхийлжээ. Тэрбээр “Засгийн газрыг огцруулах хуралд намайг байсангүй гэж сонгогчид маань үгүйсгэн шиг байна лээ. Би хуралд байсан бол үгээ хэлнэ, асуух асуултаа асууна. Огцруулах асуудлын тухайд бол би картаа сугалах байсан. Санал хураалтад оролцохгүйгээр түдгэлзэнэ гэсэн үг. Яагаад би санал хураалтад оролцохгүй байна вэ гэвэл Засгийн газрыг огцруулах үндэслэл нь өөрөө буруу байсан. МАН 65 суудалтай. Үндсэн хуулийг өөрчлөх хэмжээний улс төрийн хүчин. Энэ улс төрийн хүчний хоорондын хагаралдаанд МАХН эсвэл АН-ын зүгээс аль нэг талынх нь шийдвэрийг гаргахад нь оролцох ёсгүй юм. Яагаад гэвэл 2020 онд МАН өөрөө хариуцлагаа үүрэх ёстой. МАН сонгуульд оролцохдоо тэтгэврийн эзэлийг бууруулна, хүүхдийн мөнгийг өгнө гэдэг ч юмуу ард түмэнд таалагдсан олон амлалтыг өгсөн. Иргэд саналаа ч өгч дэмжсэн. Гэтэл хоорондоо эрх мэдэл, албан

тушаал, хардлага сэрдлэгээсээ боллоо. Хэрэв ингээгүй бол Засгийн газартаа итгэл үзүүлэх тухай асуудлыг өнөөдөр оруулж ирэх байсан юм. Хэрвээ Засгийн газрыг унагаах ёстой гэвэл бусад нам хүчний байгууллагын төлөөлөлтэй ярих байсан. Би бол Засгийн газрыг огцруулах ёстой гэж бодож байсан тал бий. Гэхдээ Засгийн газрыг огцруулахдаа одоогийн тавьсан гурван үндэслэлээр биш. Үүнээс өөр ноцтой олон үндэслэлүүд бий. Жишээлбэл, Ц.Нямдоржийн хэлж байсанчлан Эрдэнэтийн 49 хувь дээр УИХ-ын тогтоолын хэрэгжилтийг хангаагүй, идэвхтэй ажиллаагүй гэдэг ч юм уу тодорхой бөгөөд хүн болгон нээрээ огцрох ёстой юм байна шүү гэх үндэслэлүүдийг оруулж ирэх байсан.Ерөнхийлөгчийн сонгуульд ялагдсан учраас огцруулна гэдэг үндэслэл чинь өрсөлдөгч намын хувьд ямар сонсогдох вэ. Өрсөлдөгч намуудаа тэр дотроо өмнө нь удаа дараа засаг барьж байсан АН-ын тухайд Ерөнхийлөгчийн сонгуульд ялагдсан гэх үндэслэл дээр нь кноп дарж байгаа нь шившигтэй санагдсан. Та нар хэрүүлээ өөрсдөө шийд, эсвэл засгийг огцруулах тогтоолын үндэслэлүүдээ өөрчилж ир гэх байв. Засаг огцрох тухай үндэслэлд 60 тэрбум төгрөг гэсэн үг нэг ч байгаагүй. Хэрэв ингэж оруулж ирсэн бол албан тушаалын наймаа гэж үзэж, үүнийг арилгахын тулд хаацайлж байна гэж засгийг үзсэн бол оносон үндэслэл бусоз төдийгүй кноп дарах үндэслэл болно. Ингэж намын хэрүүлээ бид нараар хагалуулах гэж оруулж ирсэн нь шившигтэй хэрэг. Үнэндээ арчаагүй нөхдүүдээ солиод ажлаа урагшаа явуулах ёстой байсан болохоос биш жоомоо алах гээд гэрээ шатаав гэгчээр засгаа бүхлээр нь унагачихаар амьдрал сайжирчихгүй л дээ. Тэгээд ч одоо байгуулагдах Засгийн газар худлаа хэлдэггүй, хулгай хийдэггүй байх ёстой. Чадах зүйлээ амладаг байх ёстой” гэжээ.



Д.Содном:
МАН–ын дарга мэдрэмжтэй байсан бол бүх цохилтыг өөр дээрээ авах ёстой байсан

/Монгол Улсын Ерөнхий сайд асан/

Харин Монгол Улсын Ерөнхий сайд асан Д.Содном гуай огт өөр байр суурьтай байгаагаа хэлжээ. Тэрбээр “Төрийн эрх барьж байгаа, УИХ-д олонхй МАН дотор маш их яриа гарч байна. Бүр болохоо болиод Засгийн газраа ч огцрууллаа. Үнэхээр миний сэтгэл зовж байна. Би 1954 онд энэ намд элсч байлаа. Тиймээс МАН-д ихэд санаа чилээж суудаг. Сая болж өнгөрч байгаа үйл явдлыг ажиглахад намын удирдагчдын дотор хурц зөрчилдөөн үүсчээ. Намын удирдлагад болон Их хурал, Засгийн газарт байгаа МАН-ын 30 гаруй гишүүн ихэд дургүйцлээ илэрхийлж, хоорондоо тэмцэлдсээр байгаад Засгийн газраа огцруулчихаж байна. Үүний үндсэн шалтгааныг бодоод байхад намынхаа даргад литгэл үзүүлэхээ больчихсон юм шиг харагдаад байна. Тэрийгээ ч намынхаа даргадаа шууд хэлээд, яриад, засах асуудлаа шийдэж чадахгүй тойруулаад баахан шалтгаг эрж явсаар байгаад Засгийн газраа огцруулчихлаа. Миний хувьд үүнийг их буруу юм гэж бодож байна. Юуны өмнө МАН-ын дарга М.Энхболд нөхцөл байдалд их дүгнэлт хийх ёстой болов уу. Тэр нь дутсанаас болоод өнөөдрийн нөхцөл байдал үүсчихээд байх

Дугаарын 60 мөр Анхдагч нь анагаах боллоо

Үргэлжлэл.
Түрүүч нь I нүүрт

Уг нь дэлхийн томоохон хотууд их, дээд сургуулиудаа нийслэлийнхээ ойролцоо хотхон маягаар төвхнүүлж, тэнд багш, оюутнуудын амьдрах байр, суух номын сан, худалдаа үйлчилгээ, спорт цогцолбор гээд нийгмийн асуудлуудыг нь бүрэн төгс шийдэж өгдөг жишиг бий. Хүний анхдагч хэрэгцээ бүрэн хангагдаж, ажиллаж амьдрахад тав тухтай орчин бүрдэхээр заавал хот руу зүтгэж, замын хөдөлгөөнд түгжрэл үүсгэх, цаашлаад сургууль, цэцэрлэгийн ачааллыг нэмэгдүүлэх шаардлагагүй болно. Өдгөө нийслэлд 150 мянган оюутан амьдарч байгаа аж. Намрын намарт замын хөдөлгөөний ачаалал нэмэгддэг нь үүнтэй бас холбоотой. Харин цаасан дээр олон жил бичиж, агаарт хий хоосон ярьсан энэ сэдвийг АШУУИС-ийнхан бодит ажил хэрэг болгож байна. Өөрөөр хэлбэл, 150 мянган оюутнаас ядаж 12 мянгыг нь энэхүү шинээр барьж буй Их сургуулийнхаа хотхонд амьдруулахаар төлөвлөжээ. Зах зээлийн эрэлт нийлүүлэлтийн хуулиар 1000 гаруй багш, ажилчин шавь нараа дагаад тус хотхоныг бараадаж тэнд байранд орно гээд төсөөлөхөөр замын түгжрэл энэ хэрээр багасна. Мөн багш нар ганцаараа нүүхгүй гэр бүлээрээ нүүнэ. Очсон хойноо ойролцоох цэцэрлэг, сургуульд хүүхдүүдээ өгнө гэхээр Их сургуулийн хотхоны ач холбогдол их. Тус сургуулийн захирал Г.Батбаатар “Монголын их, дээд сургуулиудаас АШУУИС анхдагч болж нийслэл хотын хүн амын төвлөрөл, ачааллыг бууруулахын тулд оюутны хотхоноо нүүлгэх саналыг гаргаж Засгийн газар ээлжит хуралдаанаараа хэлэлцээд дэмжихээр болсон. Тиймээс багш, оюутнууд шаардлагагүй тохиолдолд хотхоноос гарахгүй байхаар орчныг нь бүрдүүлнэ. Өөрөөр хэлбэл, хүний өдөр тутмын амьдралд шаардлагатай бүх зүйлийг тэнд цогцоор нь шийднэ гэсэн үг. Зураг төсөл нь батлагдчихсан. Энэ ажил 200 гаруй тэрбум төгрөгөөр босч ирэх тооцоо бий. Бид одоогоор японуудтай хамтран ажиллаж байна. Гадаадын хөрөнгө оруулалтыг зөв татаж, байршуулж болдог гэдгийг жишиг хотхоноороо харуулна” гэж байна. Энэхүү санал санаачилгыг Монгол Улсын Засгийн газрын зүгээс ч сайн дэмжиж байгаа бөгөөд 2020 он гэхэд АШУУИС-ийн хотхоны байрууд ашиглалтад орж дуусах нь. Хамгийн гол нь бусад их, дээд сургуулиудад ч ийм боломж яг адилхан бий. Юм болгон дээр төр засаг руу чирчиг, амыг нь хараад суулгүй өөрсдөө хөдөлж болдог гэдгийг АШУУИС-ийнхан харуулж чадлаа. Ийм жишиг, туршлагаас бэлэн “жор” аваад өөрийн орны онцлогт тохируулаад авах гэхийн ухаанаар хандахад болохгүй гэх газаргүй. Тухайлбал, монголчуудын хамгийн ихээр зорчиж, бас ажиллаж, амьдардаг Солонгост хотын Инчоны их сургуулиа гэхэд зах руу нүүлгэн шинэ оюутны хотхонтой болгохыг зорьж, барилгын ажлыг нь 2008 онд эхлүүлж байжээ. Гэтэл өнөөдөр тэнд хэд хэдэн их сургууль нь нүүгээд орчихсон, тэр ч байтугай анх 2.76 сая хүн амтай хотынхоо төвлөрийг бууруулах зорилготой барьсан тус хотхон одоо хот болон сүндэрлэж байна. Сонгдо хэмээн нэрлэгддэг тэр хэсэг газрыг Инчоны эдийн засгийн чөлөөт бус болгон зарласнаар дэлхийд чансаагаараа дээгүүрт бичигддэг олон улсын их, дээд сургуулиуд ч салбараа дуртайяа нээх болсон байна.

УЛС ТӨР

Сургуулийн орчинд гар утас ашиглахыг хориглоно

Францын Боловсролын сайд Жан Мишель Бланкуэр сургуулийн орчинд ухаалаг гар утас ашиглахыг хориглохоо мэдэгдсэнээр, улс даяар хэлэлцүүлэг өрнөж эхэлсэн байна. Францын Ерөнхийлөгч Эммануэль Макрон энэ оны тавдугаар сард болсон Ерөнхийлөгчийн сонгуулиар бага болон дунд сургуулийн орчинд ухаалаг гар утас ашиглахыг хориглоно гэсэн амлалт өгч байсан юм.

Боловсролын сайд Жан Мишель Бланкуэр долоо хоног тутмын “L’Express” сонинд өгсөн ярилцлагадаа хичээлийн үеэр сурагчдыг гар утас ашиглахыг нь хориглож, ангидаа хадгалуулдаг болгох талаар дурьдсан байна. Тэрбээр “Засгийн газрын хуралдааны үеэр бүх гишүүд гар утсаа шүүгээндээ хийдэг. Үүнийг сургуулийн орчноос эхлээд олон хүн цуглардаг аль ч газарт хэрэгжүүлэх боломжтой” гэж ярьжээ.

Тэгвэл эл ярилцлага сонинд нийтлэгдсэний дараа Францад томоохон хэмжээний хэлэлцүүлэг өрнөж эхэлсэн байна. Сургуулийн орчинд гар утас ашиглах тухайд багш нар хоёр янзын байр суурь илэрхийлж байжээ. Тодруулбал, зарим багш нар ухаалаг утас хичээлд садаа болохоос гадна хүүхдийн хүмүүжилд сөргөөр нөлөөлж, интернэт орчин дахь ялгаварлан гадуурхалтын үндэс буйг онцолж байсан байна. Харин нөгөө хэсэг нь хатуу хяналт дор ухаалаг утас ашиглуулбал хичээлээ ойлгох, улам гүнзгий судлахад нь тустай гэж үзжээ.

Мөн шинжээчид, үйлдвэрчний эвлэлүүд Францын зарим сургуулийн захиргаа ухаалаг утасны хэрэглээг хориглосон байдаг ч, бодит байдалд тус дүрэм нь хэрэгждэггүй гэдгийг тодотгож байсан аж.

БНХАУ-ын онгоцны эрэлт 7000 давна

БНХАУ-ын зах зээл дэх шинэ загварын нисэх онгоцны эрэлт ирэх 20 жилд 7000-ыг давж, нийт мөнгөн дүн нь нэг их наяд 100 тэрбум ам.долларт хүрэх төлөвтэй байна.

АНУ-ын Бойнинг компани энэ сарын 6-нд өнөөгийн зах зээлийн чиг хандлагын хамгийн сүүлийн үеийн судалгааны дүнд үндэслэн нисэх онгоцны ирээдүйн төлвийг танилцуулжээ. Судалгааны дүнгээс үзвэл, манай урд хөрш БНХАУ-ын зорчигч тээврийн онгоцны эрэлт 2016 оны урьдчилсан таамагас даруй 6.3 хувиар нэмэгдсэн үзүүлэлттэй гарсан байна. Бойнинг компанийн дэд захирал Рэнди Тинсет Бээжингийн зарим хэвлэлд ярилцлага өгөхдөө “БНХАУ-ын эдийн засаг өссөөр байгаа. Үүнийг дагаад дунд давхаргынхны тоо нэмэгдэж, дэд бүтэц рүү чиглэсэн хөрөнгө оруулалт өссөн. Мөн нисэх онгоцны бизнес загварын хөгжүүлэлт өөрчлөгдсөн нь урт хугацаанд урьдчилсан таамаг гаргах үндсэн суурь болж байна.

БНХАУ дахь нислэгийн тоо дэлхийн дундажтай харьцуулахад, маш хурдацтай нэмэгдэж байгаа бөгөөд Хятадын авиа компаниуд ирэх 20 жилд дэлхийн зорчигч тээврийн онгоцны нийт эрэлтийн 20 хувийг дангаараа эзлэх төлөвтэй байна” гэж ярьжээ.

БНХАУ дэлхийн хамгийн том зах зээл болдог. Тэгвэл 2036 он гэхэд Хятадад 5420 шинэ загварын зорчигч тээврийн онгоцны эрэлт үүсэх аж. Харин энэхүү нийт эрэлтийн 75 хувийг Бойнинг компани дангаараа хангах боломжтой гэсэн урьдчилсан тооцоо ч гарчээ.



Б.ДАВАА

АНУ-аас нүүрс тээвэрлэсэн анхны хөлөг онгоц Украины боомтод хүрчээ. ОХУ-ын эрчим хүчний хараат байдлаас гарах төлөвлөгөөтэй Украин, экспортоо нэмэгдүүлэхийг зорьж буй АНУ-ын Д.Трампын захиргаа хооронд байгуулсан хэлэлцээрийн дагуу анхны тээврийн хөлөг онгоц Одесса мужийн Южный боомтод ирсэн нь энэ аж.

Хөлөг онгоцонд 62 мянган тонн нүүрс ачсан байх бөгөөд Украины Засгийн газар, АНУ-ын эрчим хүчний компаний хариуцсан ажилтнууд хүлээн авч, ачааг буулгажээ.

Украины зүүн этгээдийг хяналтдаа авсан ОХУ-ын талыг баримтлагч салан тусгаарлагчид болон Засгийн газрын армийн хооронд үүссэн мөргөлдөөний улмаас Украин цахилгаан станцуудад нийлүүлэх нүүрсний хомсдолд орсон. Улмаар сөргөлдөөн гүнзгийрэх тусам дотооддоо хангаж чадахгүйд

хүрч, импортын нүүрсээр хэрэглээгээ хангахаас өөр аргагүйд хүрсэн байдаг. Одоо ч эл нөхцөл байдал үргэлжилсээр байгаа юм.

Харин энэ оны зургадугаар сард АНУ-ын Ерөнхийлөгч Доналд Трамп ажлаа авснаасаа хойш анх удаагаа Украины Ерөнхийлөгч Петро Порошенкотой уулзсан. Тус уулзалтын дараа Украины Засгийн газар АНУ-ын эрчим хүчний компаниудаас нүүрс экспортлохоор тохиролцоонд хүрчээ.

Украины Ерөнхийлөгч Петро Порошенко АНУ-ын тээврийн хөлөг онгоц Южный боомтод хүрэх үед өөрийн биеэр хүрэлцэн очсон байна. Мөн албан ёсны фэйсбүүк хуудастаа “АНУ-ын Ерөнхийлөгч Трамптай хийсэн хэлэлцээрийн хүрээнд худалдан авсан нүүрсийг ачиж Украинд ирсэн анхны тээврийн хөлөг онгоцонд очлоо. Тэдгээр түүхий эд улсын эрчим хүчний аюулгүй байдald чухал хувь нэмэр оруулахаас гадна, стратегийн

түншүүд хоорондын харилцан ашигтай хамтын ажиллагааны тод жишээ болж байна” хэмээн бичжээ.

Украины орон нутгийн зарим агентлагийн мэдээлснээр, энэ онд Украин АНУ-аас 700 мянган тонн нүүрс импортлох төлөвлөгөөтэй байгаа аж.

АНУ-ын өнгөрсөн оны арваннэгдүгээр сарын 8-нд болсон Ерөнхийлөгчийн сонгуульд улс төрийн асар их туршлагатай Төрийн нарийн бичгийн дарга Хиллари Клинтоныг ялж, дэлхийн хүчирхэг гүрний удирдагч болсон Доналд Трампын тухайд сонгуульд өрсөлдөхөө мэдэгдсэн үеэсээ л нүүрсний импорт, экспортыг дэмжиж ажиллана гэдгээ тодотгож байсан удаатай. Тиймээс хоёр улсын хооронд байгуулсан хэлэлцээр цаашидаа тогтвортой үргэлжилнэ гэж ажиглагчид үзэж байна.

Украины цахилгаан болон дулааны цахилгаан станцууд нүүрсэнд түшиглэдэг. Гэвч, 2014 оны хоёрдугаар сараас

хойш үүссэн Украинны хямралын үеэр салан тусгаарлагчид зүүн этгээдийн бүс нутгийг хяналтдаа авснаар цахилгаан станцуудын гол түүхий эд антрацит нүүрсний нийлүүлэлт зогсоход хүрсэн юм.

Тиймээс Украин сүүлийн үед ОХУ-ын эрчим хүчний хараат байдлаас гарахад анхаарлаа хандуулах болжээ. Тус улс АНУ-аас гадна Өмнөд Африкаас нүүрс импортолж эхэлсэн бөгөөд анхны нүүрс тээвэрлэсэн хөлөг нь өнгөрөгч тавдугаар сард Украины боомтод хүрч байжээ.

Түүнчлэн, Украины Эрчим хүч, нүүрсний яам манай улсаас ч нүүрс импортлох сонирхолтой гэдгээ өмнө нь илэрхийлж байсан юм. Тодруулбал, өнгөрөгч зургадугаар сард Монголоос нүүрс импортлох асуудлыг судлах ажлын хэсэг байгуулагдсан байдаг. Гэхдээ тээвэрлэлтийн зардал өндөр тусч байгаа нь хүндрэл учруулж магадгүй гэдгийг мэргэжилтнүүд онцолж байв.

ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: 2017 оны 09 дүгээр сарын 15-ны өдөр

Тендер шалгаруулалтын нэр: **Нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүсэд орших цэцэрлэгийн нам даралтын зуухыг цахилгааны хэмнэлттэй дэвшилтэт технологиор солих ажил**
Тендер шалгаруулалтын дугаар: **НХААГ-17/0207**

Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газраас эрх бүхий тендерт оролцогчдоос “Нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүсэд орших цэцэрлэгийн нам даралтын зуухыг цахилгааны хэмнэлттэй дэвшилтэт технологиор солих ажил” нийлүүлэх тухай цахим тендер ирүүлэхийг урьж байна.

Энэхүү барааны тендер шалгаруулалт нь Цахим худалдан авах ажиллагааны системээр зарлагдаж байгаа цахим тендер тул www.tender.gov.mn хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг үнэ төлбөргүй татаж авна уу.

Тендерт оролцогч нь тендерийн баримт бичгийг илгээхийн өмнө 50,000 (тавин мянга) төгрөгийг цахим систем ашиглан төлсөн байх ёстой.

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн **45** хоногийн дотор хүчинтэй байна. Тендерт оролцогч нь санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

Борлуулалтын хэмжээ:

Сүүлийн 2 жил /2015, 2016 он/-ийн борлуулалтын орлогын дундаж нь тендерт санал болгож буй үнийн дүнгийн 30 хувиас багагүй байна.
Ижил төстэй ажил гэрээгээр гүйцэтгэсэн туршлагын мэдээлэл ирүүлэх жилийн тоо:

Сүүлийн 2 жил /2015, 2016 он/-ийн аль нэг жилд тендерт санал болгож буй үнийн дүнгийн 30 хувиас багагүй ижил төстэй ажил хийсэн байна.

Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ:
Тендерт санал болгож буй үнийн дүнгийн 30 хувиас багагүй байна.

Санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо:
Сүүлийн 2 жил /2015, 2016 он/-ийн санхүүгийн тайлан
Тендерийн баталгааны үнийн дүн: **900,000 /есөн зуун мянга/ төгрөгийн дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ.**
Цахим тендерт оролцогч цахим баталгаа гаргах эрх бүхий арилжааны банкаар цахим тендерийн баталгаа гаргуулна.
Тендерийн баталгаа хүчинтэй байх хугацаа: **2017 оны 12 дугаар сарын 28-ны өдрийг дуустал хүчинтэй байна.**
Тендерийг **2017 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн 10 цаг 00 минутаас** өмнө цахим худалдан авах ажиллагааны систем (www.tender.gov.mn)-д ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг **2017 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн 10 цаг 30 минутад** нийслэлийн Худалдан авах ажиллагааны газрын 1012 тоот өрөөнд нээнэ.
Гадаадын этгээд тендер ирүүлэхгүй. Дотоодын давуу эрх тооцно.
Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Бага тойруу-15, Самбуугийн гудамж, Нийслэлийн Засаг захиргааны 4 дүгээр байр, 10 дугаар давхар, Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар, Утас: 75757810
Цахим хаяг: www.tender.gov.mn, www.ub-procurement.mn

ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: 2017 оны 09 дүгээр сарын 15-ны өдөр

Тендер шалгаруулалтын нэр: **“УТААГҮЙ УЛААНБААТАР 2030 ТӨСЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН ХҮРЭЭНД СУРГУУЛЬ, ЦЭЦЭРЛЭГ, ЭМНЭЛГИЙН ДОТООД ОРЧНЫ АГААРЫН ЧАНАРЫГ САЙЖРУУЛАХ ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ НИЙЛҮҮЛЭХ АЖИЛ”**

Тендер шалгаруулалтын дугаар: **НХААГ-17/0210**

Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газраас эрх бүхий тендерт оролцогчдоос “Утаагүй Улаанбаатар 2030 төслийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд хийгдэх сургууль, цэцэрлэг, эмнэлгийн дотоод орчны агаарын чанарыг сайжруулах тоног төхөөрөмж нийлүүлэх ажил” нийлүүлэх тухай цахим тендер ирүүлэхийг урьж байна.

Энэхүү барааны тендер шалгаруулалт нь Цахим худалдан авах ажиллагааны системээр зарлагдаж байгаа цахим тендер тул www.tender.gov.mn хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг үнэ төлбөргүй татаж авна уу.

Тендерт оролцогч нь тендерийн баримт бичгийг илгээхийн өмнө 50,000 (тавин мянга) төгрөгийг цахим систем ашиглан төлсөн байна.

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн **45** хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна.

Үүнд:
Борлуулалтын хэмжээ:

Сүүлийн 2 жил / 2015, 2016 он/-ийн борлуулалтын орлогын дундаж нь тендерт санал болгож буй үнийн дүнгийн 30 хувиас багагүй байна.

Ижил төстэй ажил гэрээгээр гүйцэтгэсэн туршлагын мэдээлэл ирүүлэх жилийн тоо:

Сүүлийн 2 жил буюу 2015, 2016 онуудын аль нэг жилд тендерт санал болгож буй үнийн дүнгийн 30 хувиас багагүй ижил төстэй ажил хийсэн байна.

Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ:
Тендерт санал болгож буй үнийн дүнгийн 30 хувиас багагүй байна.
Аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо:
Сүүлийн 2 жил буюу /2015, 2016 он/
Тендерийн баталгааны үнийн дүн: **1,000,000 /нэг сая/ төгрөгийн дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ.**
Цахим тендерт оролцогч цахим баталгаа гаргах эрх бүхий арилжааны банкаар цахим тендерийн баталгаа гаргуулна.
Хүчинтэй байх хугацаа: **2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал хүчинтэй байна.**
Тендерийг **2017 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн 11:00 цагаас** өмнө системд ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг **2017 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн 11:30 цагт** Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газрын 1012 тоот өрөөнд нээнэ.
Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхгүй. Дотоодын давуу эрх тооцно.
Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Бага тойруу-15, Самбуугийн гудамж, Нийслэлийн Засаг захиргааны 4 дүгээр байр, 10 дугаар давхар, Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар, Утас: 75757810
Цахим хаяг: www.tender.gov.mn, www.ub-procurement.mn

СПОРТ

ДЭЛХИЙН ДЭВЖЭЭНД ЭХ ОРНЫХОО НЭРИЙГ ДУУРСГАСАН
ТАМИРЧИДЦАА ХҮНДЭТГЭЛ ҮЗҮҮЛЛЭЭ

VI нүүрт

FOOTBALL NEWS

Роналдо Мессигийн рекордыг эвдлээ

Аваргуудын лигийн эхний тойргийн хүрээнд Испанийн “Реал Мадрид” клуб өнгөрсөн лхагва гарагийн шөнө Киприйн “АПОЭЛ” багийг хүлээж авч, 3:0-ээр буулгаж авсан билээ. Энэ тоглолтод “Реал”-ын супер од хоёр гоол оруулсан. Ингэснээр Аваргуудын лигт 107 гоолтой болж, амжилтаа ахиулсаар байна. Тэгвэл тэрбээр мөн Мессигийн нэгэн рекордыг эвдсэн юм. Роналдо хоёр дахь гоолоо торгуулын цохилтоос оруулсан. Ингэснээр Аваргуудын лигт торгуулын цохилтоор 12 дахь гоол оруулж буй нь энэ юм. Месси 11 гоолыг торгуулын цохилтоос оруулж байжээ.

Аваргуудын лигийн эхний тойрогт 54 гоол орж, рекорд тогтоолоо

Европын хамгийн нэр хүндтэй тэмцээн болох Аваргуудын лигийн 2017-2018 оны улирлын тоглолтууд эхэлсэн билээ. Мягмар, лхагва гарагийн шөнө Аваргуудын лигийн эхний шатны 16 тоглолт болж, нийтдээ 54 гоол оржээ. Энэ нь Аваргуудын лигийн нэгдүгээр шатанд орж байсан гоолын хувьд рекорд үзүүлэлт аж. Өмнө нь хэзээ ч нийм олон гоол нэгдүгээр шатанд орж байгаагүй юм байна. Гэхдээ энэ бол Аваргуудын лиг одоогийн форматаар зохион байгууллагддаг болсноос хойш гарч буй үзүүлэлт юм. Өмнө нь 2000-2001 оны улиралд эхний шатанд 63 гоол орж байсан ч формат нь өөр байсан билээ.

АВАРГУУДЫН ЛИГИЙН НЭГДҮГЭЭР ШАТАНД ОРЖ БАЙСАН ГООЛУУД

2003/04 — 40	2011/12 — 32
2004/05 — 31	2012/13 — 43
2005/06 — 37	2013/14 — 53
2006/07 — 42	2014/15 — 43
2007/08 — 36	2015/16 — 48
2008/09 — 36	2016/17 — 50
2009/10 — 37	2017/18 — 54
2010/11 — 44	

МЭДЭЭЛЭЛ

Э.Бэхбаярын мэх шилдгийн жагсаалтыг тэргүүлжээ

Дэлхийн нэгдсэн бөхийн холбооноос “Парис-2017” чөлөөт бөхийн насанд хүрэгчдийн ДАШТ-ий шилдэг арван мэхийг танилцуулжээ. Бахархалтай нь эрэгтэйчүүдийн 57 кг-д зодоглосон Э.Бэхбаяр эхний тойрогт Киргизстаны

Улукбек Жолдошбековтой хийсэн барилдааны мэх шилдэг арвын жагсаалтыг тэргүүлэв. МонголУлсынгавьяаттамирчин Эрдэнэбатын Бэхбаяр эрэгтэй баг тамирчдаас ганцаараа хүрэл медаль хүртснээр дэлхий хошой медальтан болсон билээ.



Олимп, дэлхийн аварга мэргэн буучид Монголд ирлээ

“S-Sport Mongolia” Төрийн бус байгууллагаас санаачлан “Барселона-1992” зуны олимпын XXV наадмаас буудлагын төрлөөр хүрэл медаль хүртсэний 25 жилийн ойг энэ өдрүүдэд тэмдэглэж байгаа билээ. Түүхэн ойд зориулж “Барселона-1992” олимпын наадмын хүрэл медальт, Монгол Улсын Гавьяат тамирчин Д.Мөнхбаярт зориулсан хүндэтгэлийн тэмцээн, уулзалтыг зохион байгуулж байгаа юм. Ёслол, уулзалт, халз тэмцээнд Д.Мөнхбаяргавьяатынурилгаар оролцож буй олимп, дэлхийн домогт мэргэн буучид болох Мариа Гроздева (Болгар), Ясна Секарич (Серби), Нино

Салуквадзе (Гүрж) нар өчигдөр Улаанбаатар хотод хүрэлцэн ирлээ. Болгарын шилдэг мэргэн бууч Мариа Гроздева Олимпын хошой алт, гурван хүрэл медальтай тамирчин юм. Харин Сербийн тамирчин Ясна Секарич Олимпын алт, гурван мөнгө, нэг хүрэл, ДАШТ-ий гурван алт, нэг мөнгө, хоёр хүрэл медаль хүртэж байсан шилдэг мэргэн бууч билээ. Гүржийн Нина Салуквадзе Олимпын алт, мөнгө, хүрэл, ДАШТ-ий зургаан алт, хоёр мөнгө, нэг хүрэл медальтай тамирчин. Тэд өнөөдөр “туушин” зочид буудалд залуучуудтай уулзалт зохион байгуулж, чөлөөтэй ярилцах юм.



Б.МӨНГӨНЧИМЭГ

ЯМАР Ч ТОМ БӨХТЭЙ ӨӨРИЙНХӨӨРӨӨ БАРИЛДААД, ЯЛНА Л ГЭЖ БОДДОГ

–Би чинь монгол хүн шүү гэж бодож, хурцлагдаж дэвжээнд гардаг–

Н.ПУНЦАГБОЛД

Унгарын нийслэл Будапешт хотноо жүдо бөхийн ДАШТ болсон билээ. Өнөө жилийн дэлхийн аваргаас Монголын жүдочид зургаан медаль авч, багийн дүнгээр дэлхийн 126 орноос гуравдугаар байрт шалгарсан. Тэгвэл энэ удаагийн дэлхийн аваргын 63 кг-д улсаа төлөөлөн оролцсон Б.Мөнгөнчимэг хүрэл медаль хүртэж, бөмбөрцөгт нэрлэн дансалсан юм. 23 насандаа дэлхийн медальтан түүнтэй ярилцсанаа уншигч авхай танд хүргэе.

–Унгарт болсон ДАШТ-д амжилттай оролцож, хүрэл медаль хүртсэн. Тэмцээнд оролцохын өмнө сэтгэл санаа, бэлтгэлжилт ямар байв?

–Би тэмцээн эхэлчихсэн байхад очсон. Эндээс явах нислэг тэгж таарсан юм. Унгарт очиход уур амьсгал Монголтой төстэй, нэг их ялгаагүй байсан. Очсон өдрөө жин тохируулах бэлтгэл хийсэн. Өглөө Будапешт хотод буугаад, өдөр нь бэлтгэлээ хийчихээд, маргааш нь жингээ үзүүлсэн. Түүнийхээ дараа барилдах хүмүүсийнхээ талаар жаахан судалж байгаад барилдах өдрөө тэмцээний заал руу очсон. Сугалаа тэмцээн эхлэхээс өмнө гарчихсан байсан. Барилдах хүмүүсээ хараад, эхний тойрогт Энэтхэгийн бөхтэй юм байна. Хэврээ ялчихвал Финландтай тулах юм байна гэж бодоод, бэлдэж байлаа. Финландтай аятайхан барилдаад ялбал Францын бөх гарч ирэх юм байна гээд тооцоолж байлаа. Тэгээд тэр бөхчүүдийн барилдааныг харж, энэ нь баруун талтай, тэр нь зүүн талтай юм байна гэх мэтчилэн

харж, ажиглаж, судалж байсан. Барилдааны өмнө бол сэтгэл санаа сайхан байсан шүү. Гараад сайхан барилдая л гэж бодож байлаа.

–Барилдаануудынхаа талаар ярьвал. Эхний тойргуудад өөгүй сайхан барилдсан шүү дээ?

–Эхний тойрогт Энэтхэгийн бөхийг хөмөрч, базарч авсан. Улмаар үргэлжлүүлж дарах мэхээр цэвэр хожсон. Харин хоёрдугаар тойрогт Финландын бөхтэй нэлээд удаан барилдсан. Барьц авахаар л сөхөж үүрэх гээд байсан юм. Тэр нь жаахан эвгүй. Өмнө нь барилдаж үзээгүй байсан болохоор бүр эвгүй. Эхний хоёр минут гаран барилдаан сайн гарч өгөөгүй. Сүүлийн нэг минут ороод ирсэн чинь багш “Одоо яваад барилд, цаг дууслаа шүү” гэсэн. Тэгэхээр нь энгэрийнхээ барьцыг авч байгаад хөмөрч үзсэн. Миний хөмрөөнд унахгүй байхаар нь хөмрөх гэж хуураад тохож унагаж, базари үнэлгээ аваад, улмаар даралтаар цэвэр ялсан. Гурав дахь барилдаанаа Францын

бөхтэй хийсэн. Өмнө нь Маркес Пинот гэдэг Францтай нэг удаа таарч барилдаад ялагдчихсан байсан юм. Сууж үүрдэг мэхтэй. Тэр мэхийг нь хийлгэхгүй гэсэн тактиктэй барилдсан. Тактикийнхаа дагуу мэхээ хийгээд, барилдсан. Эхний нэг минут өнгөрөөд ирэх үед нэг үнэлгээ авах ёстой гэж бодоод, улмаар хөмөрч базарч авсан. Цаг дуустал үнэлгээгээ хамгаалаад л дуусгасан даа. Ингээд шигшээ найм руу орсон.

–Хэстийн аваргын төлөө дахиад Францын бөхтэй учраа таарсан байх аа?

–63 кг-ын чансаанаа хоёрт бичигддэг, дэлхийн аварга, Олимпын мөнгөн медальт Кларинс Агбененутай барилдсан. Уг нь эхлээд баруун талаараа барьц аваад барилдана гэсэн тактик боловсруулж татамид гарсан. Гарсныхаа дараа зүүнээрээ барилдаж болмоор санагдаад барьц автал өрсөлдөгч маань үндсэн мэхээ хийгээд л цэвэр ялчихсан, намайг.

Үргэлжлэл нь VII нүүрт

СПОРТ

ДЭЛХИЙН ДЭВЖЭЭНД ЭХ ОРНЫХОО НЭРИЙГ
ДУУРСГАСАН ТАМИРЧИДДАА ХҮНДЭТГЭЛ ҮЗҮҮЛЛЭЭ

П.НАРАНДЭЛГЭР

Монгол түмний бахархал болж, тив дэлхийд нэрээ дуурсгасан тамирчдад хүндэтгэл үзүүлэх ёслол өчигдөр БСШУСЯ болон МУБИС-д боллоо. БСШУСЯ-ны хүндэтгэлийн танхимд жүдо бөхийн “Будапешт-2017”, чөлөөт бөхийн “Парис-2017”, сонирхогчдын боксын “Хамбург-2017” насанд хүрэгчдийн ДАШТ-ээс алт, мөнгө, хүрэл медаль хүртсэн тамирчдад хүндэтгэл үзүүлэх үйл ажиллагаа болсон юм. БСШУС-ын сайдын үүрэг гүйцэтгэгч Г.Чулуунбаатар ёслолын үеэр “Монгол Улсын эдийн засаг харьцангуй хүндрэлтэй байгаа ч манай биеийн тамир спортын салбарынхан улс орныхоо нэр төрийг дэлхийн тавцанд гаргаж чадлаа. Та бүхнийг тив дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд хэрхэн оролцож байгааг хэвлэл мэдээллийн сувгуудаар бахархал дүүрэн харж байсан шүү. ХБНГУ-ын Хамбург хотноо болсон сонирхогчдын боксын насанд хүрэгчдийн ДАШТ, Францын Парис хотноо болсон чөлөөт бөхийн ДАШТ, Унгар улсын Будапешт хотноо зохиогдсон жүдо бөхийн ДАШТ-д амжилттай оролцсон тамирчид, спортын гурван холбоодын багш дасгалжуулагч нарыг хүлээн авч талархал илэрхийлж байна. Монгол Улсаа дэлхийд сурталчилдаг та бүхэн маань эх орныхоо түүхийг мэддэг байх ёстой гээд “Дэлхийд түгсэн Монголын нууц товчоо” нэртэй

номыг бэлэглэж байна. Та бүхэн спортын өндөр амжилт гаргаж, эх орныхоо нэрийг дэлхийн дэвжээнд олон дахин гаргаж явахын ерөөл өргөө” хэмээлээ. Хүндэтгэлийн үйл ажиллагааны үеэр тамирчид болон багш дасгалжуулагч нарт дурсгалын зүйл гардуулсан юм. Харин МУБИС-ийн Биеийн тамирын сургуулийн хамт олон тус сургуулийн төгсөх ангийн



оюутан, МУТТ, Дэлхийн аварга Д.Сумьяа, Дэлхийн аварга П.Орхон, Дэлхийн аваргын хүрэл медальт Д.Отгондалай нарт хүндэтгэл үзүүллээ. Энэ үеэр тус сургуулийн захирал Р.Бат-Эрдэнэ “МУБИС-ийн БТС-ийн оюутнууд та бүхнийг дэлхийн аварга болоосой, тив дэлхийд нэрээ дуурсгаасай, амжилттай яваа тамирчдаас туршлага судлаасай гэсэндээ энэхүү хүндэтгэлийн үзүүлэх үйл ажиллагааг зохион байгуулж байна. 66 жилийн түүхтэй МУБИС-иас



Гэрэл зургийг П.НАРАНДЭЛГЭР

эх орондоо төдийгүй дэлхийд нэрээ дуурсгасан алдартнууд олноор төрөн гардаг. Эх орныхоо төлөө хөлс хүчээ гаргаж яваа тамирчид маань өөрийн боловсролдоо байнга анхаараад байх цаг зав хомс байдаг. Тийм учраас энэ боломж бололцоог хангах үүднээс манай сургуулийн удирдлагууд ярилцаад гурван оюутнууддаа магистрын 100 хувь тэтгэлэгтэй суралцах эрхийн бичгээр шагнаж байна” гэлээ. МУТТ Дэлхийн аварга Д.Сумьяа энэ үеэр “Юуны өмнө

хайртай сургуулийн маань хамт олон биднийг хүндэтгэлтэйгээр хүлээн авч байгаад маш их талархаж байна. Энд хүрэлцэн ирсэн оюутан дүү нартаа захиж хэлэх хэдэн үг байна. Хамгийн түрүүнд та бүхэн өөрсдийн өмнө зорилго тавиарай. Миний хувьд жүдо бөхийг өөрийн зорилгоо болгосон. Сонгосон мэргэжилдээ би тийм төвшинд хүрнэ. Түүнийгээ биелүүлэхийн тулд би хаанаас, юунаас эхлэх вэ гэж шат дараалсан ажлын төлөвлөгөө гаргах хэрэгтэй. Өөртөө итгэлтэй байж,

миний чадамж хэр байх вэ гэж бодоорой. Бид монгол хүмүүс. Өнөөдөр бид дэлхийд монголчууд чадаж байна гэж харуулах ёстой. Бид гурав үе үеийн алдартай тамирчидийн үргэлжлэл. Та бүхэн ч бидний үргэлжлэл. Дашрамд сонирхуулахад, жүдо бөхийн дүрэмшинчлэгдсэнээс хойш анх удаа 13 минут барилдсан. Япон бөхийн хувьд би өмнө нь гурав хожигдож, нэг удаа ялж байсан, нэг нэгнийхээ барилдааныг мэддэг байсан. Тухайн үед хөлс хүч шавхаж, их цуцсан. Тэгээд

дэвжээний захад хэсэг өвдөг нугалаад сууж байхдаа “Эцсийн шийдвэрлэх барилдааныг хийе” гээд нэг сайхан урт амьсгаа аваад барилдсан. Би ерөнхийдөө зүүн талын барьц авдаг гэдгийг өрсөлдөгч маань мэддэг, гэхдээ хааяа нэг хийдэг баруун талаар барилдвал болчихмоор санагдсан. Тэр мэх маань амжилт авчирсан. Тиймээс тамирчин хүн өөртөө итгэлтэй, зоригтой, шийдэмгий байх хэрэгтэй гэдгийг захимаар байна” гэлээ.

ҮНИЙН САНАЛ АВАХ
УРИЛГА

2017.09.15

Баянзүрх дүүргийн Худалдан авах ажиллагааны алба нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос Баянзүрх дүүргийн 20 дугаар хороо, Туулын 2, 3, 10, 11, 18, 19 дүгээр гудамж дундах гэрэлтүүлгийн угсралтын ажил, БЗДХААА-17/520-ыг гүйцэтгэх тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Үнийн саналыг 2017 оны 09 дүгээр сарын 22-ны өдрийн 09 цаг 00 минут-аас өмнө Баянзүрх дүүргийн Засаг даргын Тамгын газрын байр, 1 давхарт 121 тоот хаягаар ирүүлнэ.

Үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан 2017 оны 09 дүгээр сарын 22-ны өдрийн өдрийн 09 цаг 30 минут-д нээнэ.

Монгол Улсын гарал үүсэлтэй бараанд давуу эрхийн зөрүү тооцохгүй.

Тендерийн баримт бичгийг эргэн төлөгдөхгүй нөхцөлтэйгөөр 50000 төгрөгөөр худалдана. Мөнгө тушаах данс: Баянзүрх дүүрэг Төрийн сан Худалдан авах ажиллагааны алба 100200355027

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Монгол улс, Улаанбаатар-51
Баянзүрх дүүрэг, Энхтайваны өргөн чөлөө-57
13 дугаар хороо, Засаг даргын Тамгын газрын байр,
1 давхарт 121 тоот, Худалдан авах ажиллагааны алба Утас:70154446

ҮНИЙН САНАЛ АВАХ
УРИЛГА

2017.09.15

Баянзүрх дүүргийн Худалдан авах ажиллагааны алба нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос Баянзүрх дүүргийн 08 дугаар хороо, Улаанхуарангийн эцсээс цагдаагийн өргөн чөлөөний петровис ШТС хүртэлх гэрэлтүүлгийн угсралтын ажил, БЗДХААА-17/521-ыг гүйцэтгэх тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Үнийн саналыг 2017 оны 09 дүгээр сарын 22-ны өдрийн 09 цаг 00 минут-аас өмнө Баянзүрх дүүргийн Засаг даргын Тамгын газрын байр, 1 давхарт 121 тоот хаягаар ирүүлнэ.

Үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан 2017 оны 09 дүгээр сарын 22-ны өдрийн өдрийн 09 цаг 45 минут-д нээнэ.

Монгол Улсын гарал үүсэлтэй бараанд давуу эрхийн зөрүү тооцохгүй.

Тендерийн баримт бичгийг эргэн төлөгдөхгүй нөхцөлтэйгөөр 50000 төгрөгөөр худалдана. Мөнгө тушаах данс: Баянзүрх дүүрэг Төрийн сан Худалдан авах ажиллагааны алба 100200355027

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Монгол улс, Улаанбаатар-51
Баянзүрх дүүрэг, Энхтайваны өргөн чөлөө-57
13 дугаар хороо, Засаг даргын Тамгын газрын байр,
1 давхарт 121 тоот, Худалдан авах ажиллагааны алба Утас:70154446

ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: 2017.09.15

Тендер шалгаруулалтын нэр: Баянзүрх дүүргийн 3 дугаар хороо 9 дүгээр байрны зүүн талд хүүхдийн тоглоомын талбай байгуулах ажил
Тендер шалгаруулалтын дугаар: БЗДХААА-17/106

Баянзүрх дүүргийн Худалдан авах ажиллагааны алба нь эрх бүхий тендерт оролцогчдоос Баянзүрх дүүргийн 3 дугаар хороо 9 дүгээр байрны зүүн талд хүүхдийн тоглоомын талбай байгуулах ажил-ыг гүйцэтгэх тухай битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна.

Тендерийн баримт бичгийг (хүсвэл нэмэлт хувийг) бичгээр хүсэлтээ гаргаж, эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдэл бүрийг нь 100,000 төгрөгөөр худалдан авч болно. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 45 хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна.

Үүнд:

Борлуулалтын хэмжээ:

Сүүлийн 2 жилийн /2015, 2016 он/ борлуулалтын орлого нь тус бүр 200 саяаас багагүй байх.

Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ:

Санал болгож буй үнийн дүнгээсээ багагүй байна.

Аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо:

2015, 2016 он

Сүүлийн гурван жилд хэрэгжүүлсэн ижил төстэй ажлын өртөг:

Сүүлийн 3 жилийн /2014, 2015, 2016 он/ аль нэг жилийн хугацаанд дор хаяж 2 удаа тус бүр 100 сая төгрөгөөс дээш өртөгтэй ажил дээр үндсэн гүйцэтгэгчээр ажилласан байна.

Тусгай зөвшөөрөл шаардлагатай бол тусгай зөвшөөрөл ирүүлэх эсэх:

2.1.1 Барилгын засвар, засал чимэглэл орчны тохижилтын ажил гүйцэтгэх зөвшөөрөл.

Тендерийн хамт 1,800,000 төгрөгийн дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ.

Тендерийг 2017 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн 09 цаг 00 минут-аас өмнө доорх хаягаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг 2017 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн, 09 цаг 30 минут-д нээнэ.

Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхгүй.

Дотоодын давуу эрх тооцно.

Төлбөрийн хийх хэлбэр: Дансаар тушаана.

Банкны нэр: Баянзүрх дүүргийн Төрийн сан

Дансны дугаар Т: 100200355027

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Монгол улс, Улаанбаатар-51
Баянзүрх дүүрэг, Энхтайваны өргөн чөлөө-57
13 дугаар хороо, Засаг даргын Тамгын газрын байр,
1 давхарт 121 тоот, Худалдан авах ажиллагааны алба Утас:70154446

СПОРТ

Үргэлжлэл. Түүрүүч нь V нүүрт

Ингээд л торгуулийн тойрогт шилжсэн. Миний өмнө Одбар ах, Сумьяа эгч хоёр барилдсан шүү дээ. Манай жүдочид нэг фэйсбүүк грушптэй байхгүй юу. Тэр групп дотор Түвшээ аварга “Одбаярыг яг тэмцээн эхэлж байгаа юм шиг л барилдаарай гэж хэлээрэй” гэсэн юм. Одбаяр ах бас торгуульд барилдсан шүү дээ. Тэгээд торгуулийн тойрогт барилдахдаа тэр үгийг санаж, тэмцээн эхэлж байгаа юм шиг л үзье гэж бодсон. Хэрвээ тэмцээн эхэлж байгаа юм шиг барилдвал хоёр ялаад л медаль хүртэнэ шүү дээ. Медалийн төлөө барилдах гэж байна даа гэж сандарсан юм байгаагүй. Торгуулийн тойрогт Бразилийн бөхтэй барилдахад намайг эхлээд нэг шидэх гэж оролдсон. Багш нар ч гэсэн “Наад шидээ чинь ирнэ шүү” гэж хэлж байсан юм. Тэгтэл дахиад шидэх мэхний оролдлого хийхээр нь хойш татаад, дарах барьц аваад, цэвэр ялсан. Харин хүрлийн төлөө Хятадын Ян Жунха гэдэг бөхтэй барилдсан. Өмнө нь тэр бөхтэй дөрвөн удаа барилдсан. Нэг хожиж, гурав дараалж хожигдсон. Медалийн төлөө гарахдаа өмнө нь хожигдсоноо ч мартчихсан. Барилдахын өмнө Сумьяа эгч ирээд, гар барьж өгсөн. Тэгээд “За одоо дэвжээн дээр гарахаар чинь Монгол гээд хашгирна. Үзэгчид дэмжинэ. Түүнд битгий их анхаараарай, барьцаа аваад, барилдаанаа хийгээрэй” гэж хэлсэн. Би

авчихмаар санагдаад байх юм” гээд хэлтэл “Чимээгүй, дотроо л хадгалж бай” гэж хэлж байлаа. Бас ээждээ “Ээжээ, би энэ жил дэлхийн аваргаас медаль авнаа” гэж хэлж байсан юм. Ээж маань ч юм дуугардаггүй. Дотроо л хадгал гэсэн санаа нь байсан юм шиг байна лээ. Сумьяа эгч өмнөх өдөр нь алтан медаль авчид хэлсэн. Тэгтэл “За за явж хүрлээ авчихаад ир” гээд явуулсан. Тэгээд медалиа аваад ирсэн чинь “Чи өглөө юу гээд байлаа” гээд л баяр хүргээд, үнэхээр гоё байсан.

-Хятадын бөхийг цэвэр ялчихаад нэг их сэтгэл хөдлөл гаргахгүй байсан юм. Илүү том зорилготой ирээд, хүрэл медаль авсан болохоор тэгсэн юм болов уу гэж бодож байсан шүү?

-Тухайн үедээ сэтгэл хөдлөлөө барьчихсан юм. Цэвэр ялсан гэж бодоогүй, базаригаар л унагалаа гэж сэтгэхгүй юу. Тийм болохоор цэвэр зааснаа болнод базари болгочихвол хэцүү шүү дээ. Баярлаад, хөөрөөд гүйчихдэг, үнэлгээгээ болиулаад дахиад барилдахаар болбол хэцүү биз дээ. Сэтгэл хөөрөөд, баярлагчихсан байсан хүн буцаж төвлөрөөд барилдахад амар биш. Тэгээд л базари авсан гэж бодоод л шүүгч рүү хараад зогсч байсан

Багш, дасгалжуулагчид, холбоо энэ тэмцээнд оролц гэвэл тэгээд л явна даа.

-Тамирчин болгонд үлгэр дуурилал авдаг хүн байдаг байх. Өөрийн тань хувьд хэнээс үлгэр дуурилал авч, суралцдаг вэ?

-Шигшээ багийнхан чинь эрэгтэй, эмэгтэийгүй хамт бэлтгэл хийдэг. Тийм болохоор шигшээгийнхээ тамирчдаас үлгэр дууриалал авч, суралцана. Болдоо ах мэдрэмжтэй, гоё барилддаг. Урнаа эгч техниктэй, хэвтээ барилдаанд сайн. Тийм болохоор хэвтээд яаж барилдаж байна вэ гэдгийг харна, суралцана. Сумьяа эгч байна, дайчин, тэвчээртэй, гайхалтай барилддаг бөх. Сая 13 минут ажиллаж, барилдсан. Тэр барилдааныг хараад “Энэ хүн ингэж ажиллаж, барилдаж чадаж байна. Би ч гэсэн чадна шүү дээ” гэсэн бодол төрж байсан. Одбаяр ах бас гоё барилдана. Тэр бүх барилдааныг харж, суралцаж, үлгэр дууриалал авдаг. Ер нь л байнга хамт бэлтгэл хийж байгаа юм чинь харна, сурч авна шүү дээ. Урнаа эгчийн барилдааныг бол байнга харна. Бүгдийг нь сурахгүй ч гэсэн даралтыг яаж авч байна гээд л харна, суралцана.

-Хэвтээ барилдаанд илүү сайн барилддаг болсон юм шиг санагдсан. Сая дэлхийн аваргаар гэхэд л хэд хэдэн удаа даралтаар ялсан шүү дээ?

-Босоо барилдаанаас хэвтээ рүү шилжих шилжилтэд илүү



Гэрэл зургийг П.НАРАНЦЭЛЭГ

ЯМАР Ч ТОМ БӨХТЭЙ ӨӨРИЙНХӨӨРӨӨ БАРИЛДААД, ЯЛНА Л ГЭЖ БОДДОГ

–Би чинь монгол хүн шүү гэж бодож, хурцлагдаж дэвжээнд гардаг–

ч гараад л барилдчихъя гэж бодсон. Гараад барьцаа аваад, хөмрөөд унагаасан. Шүүгч рүү харсан чинь цэвэр гэж заахгүй юу. Би өөрөө болохоор базари үнэлгээ авчихлаа л гэж бодсон. Цэвэр унасаныг нь мэдэхгүй шүү дээ. Тэгээд цэвэр заасныг болиулаад базари болгох байх гэж бодоод, гайхаад зогсч байсан. Гэтэл ялалт заачихсан. Түүний дараа дэвжээнээс буугтаад, гэнэт баярлаад гүйсэн дээ. Хүмүүс болохоор намайг тэрхэн зуур цочролд орчихсон уу гээд л байсан.

-Францын Агбененуг ялчихвал манай бөх финалд үлдэх ч боломж байна даа гэж би харж байсан юм. Гэтэл амархан ялагдчихсан?

-Нөгөө зооноос хэсгийн аваргаар Польшийн бөх гарч ирсэн. Тэр бөхийг би 2014 онд багийн дэлхийн аваргаар хожиж байсан. Хэрвээ Францыг ялсан бол финалд үлдэх боломжгүй гэх газаргүй. Мэдээж хожно л гэж дэвжээнд гарна шүү дээ. Хожигдоно гэж юу гэж бодох вэ дээ. Гэвч барьцны алдаанаас болоод л ялагдчихсан. Ялагдчихаар чинь босч ирээд нэг хэсэгтээ л учраа олдоггүй юм билээ. Нэлээд барилдаж байгаад ялагдсан бол тэгэх бодно. Гэтэл гараад л уначихаар чинь дараагийн барилдаанаа л сайн хийе гэхээс өөр юм бодогддоггүй юм билээ. Тэгээд ч өмнөх өдрүүдэд 48, 60, 57, 73 кг-ын жингийн бөхчүүд медаль хүртсэн болохоор сэтгэл зүй огт өөр болчихсон. Хамт бэлтгэл хийсэн хүмүүс маань медаль авч болоод байхад би яагаад чадахгүй гэж бодох жишээний.

-Дэлхийн аваргад явахдаа медаль авч чадна гэж бодож явсан уу. Хэр өөртөө итгэлтэй байсан бэ?

-Медаль авчихмаар санагдаад байсан байхгүй юу. Найз залуудаа ч хэлж байсан. “Би энэ удаагийн ДАШТ-ээс медаль

юм. Гэтэл цэвэр ялалт заачихаар нь “Юу билээ” гээд л гайхаж байгаа юм чинь. Түүнээс биш би чинь сэтгэлийн хөдлөл ихтэй хүн. Хүрэл медалийг чамлана гэж юу байхав. Дэлхийн аваргын медаль гэдэг чинь ямар өнгөтэй байх нь чухал биш. Медаль л медаль. Гэхдээ би алтан медаль бол авна гэсэн зорилготой л очсон юм уг нь.

-Медалийн тавцан дээр зогсч байх үед чухам юу бодогдож байх юм?

-Гаргах амжилтуудынхаа эхлэлээс атгаад авчихлаа даа гэж бодсон. Би чадлаа шүү дээ гэж бас бодогддог юм билээ. Бас ээж рүүгээ залгаад “Би чадчихлаа шүү дээ” гэж хэлсэн. Дэлхийн аваргаас медаль хүртэхэд тайлбарлаж боломгүй тийм гоё мэдрэмж төрдөг юм билээ. Тэгээд ч цаашид барилдах барилдаан болгонд нөлөөлнө. Би чинь дэлхийн аваргын медальтай бөх шүү дээ гэж бодоод барилдахад арай өөр үзнэ шүү дээ. Нөгөө талаар бас хариуцлага нэмэгдэж байна. Монголчууд л гэхэд Мөнгөнчимэг одоо ингэж барилдана, сайн амжилт үзүүлнэ л гэж найдаж, харна биз дээ. Тийм учраас хариуцлага нэмэгдэж байгаа байх.

-63 кг-ын жингийн бөхчүүдийн ур чадвар жилээс жилд өсч байна. Дэлхийн медальтан хоёр ч төрлөө. Түүний нэг нь өөрөө. Цаашид ямар зорилго тавьж байна, өөртөө?

-Холын зорилго бол Токиогийн олимп байна. Харин ойрын гэвэл удахгүй болох тэмцээнүүдэд амжилттай оролцоно доо. Токиогийн их дуулга болно. Он гараад Европын цувралууд эхэлнэ. Тэгээд мэдээж дараа жилийн дэлхийн аварга шалгаруулах тэмцээн байна. Гаргасан амжилтгаа давтаж, улам ахнулахыг бодож бэлтгэлээ хийнэ дээ. Ойрын үед болох тэмцээнүүдэд оролцох эсэх нь одоохондоо тодорхойгүй байна.

анхаарсан бэлтгэлийг их хийлгэсэн. Нэг долоо хоногтоо байнга босоо барилдааны бэлтгэл хийсэн. Харин дараа долоо хоногтоо босоогоос хэвтээ рүү шилжиж барилдах бэлтгэл хийж байлаа. Тийм болохоор сая дэлхийн аваргаар тэр бэлтгэлийнхээ дагуу барилдаад, даралт авч ялсан нь тэр. Ер нь бэлтгэл жигд сайн болсон. Бүгдээрээ л сайн барилдсан. Муу барилдсан хүн байхгүй. Багш нарын төлөвлөгөө сайн байсан. Бэлтгэл хангагч дүү нар ч сайн байсны ачаар үр дүнд хүрлээ. Зургаан медаль хүртэнэ гэдэг бол үнэхээр том амжилт.

-Нэгэн үе манай тамирчид Япон, Солонгос, Франц гэх зэрэг орны бөхчүүдтэй таарахдаа ялахгүй гэсэн сэтгэл зүйтэй байгаад байх шиг санагддаг байлаа. Харин одоо бол гадаадын тамирчид Монголын бөхтэй таарахаасаа эмээдэг болсон байх шүү. Ер нь ямар ч орны бөхөөс айхгүй үздэг болсон биз?

- “Би чинь монгол хүн шүү дээ” гэж бодоод, хурцлагдаад дэвжээнд гардаг. Нэг үеэ бодвол Монголын жүдочид ямар ч тэмцээнээс медаль авдаг болчихсон. Багийн дүнгээр эхний гуравт ордог болчихсон. Тийм болохоор гадны тамирчид монголчууд хүчтэй өрсөлдөгч гэдэг сэтгэл зүйтэй болчихсон байдаг байх. Бид ч гэсэн тэр орны тамирчид биднээс илт илүү, ялахгүй гэж бодохоо болсон. Хэнтэй ч өөрийнхөөрөө барилдаад, ялна л гэж боддог.

-Мөнгөнчимэгийг уран нугаралтаар хичээллэж байгаад жүдод орсон гэдэг юм билээ. Хэзээнээс жүдо бөхийн спортоор хичээллэж эхэлсэн бэ?

-Нэгдүгээр ангиасаа эхлээд тавдугаар анги хүртлээ уран нугаралтаар хичээллэсэн. Таван жил уран нугарсан. Тэр үедээ эгмээ хугалаад, хоёр сар гэртээ байсан. Гэртээ хэвтэхээр жин нэмчихэж байгаа юм чинь. Жин

...Сумьяа эгч байна, дайчин, тэвчээртэй, гайхалтай барилддаг бөх. Сая 13 минут ажиллаж, барилдсан. Тэр барилдааныг хараад “Энэ хүн ингэж ажиллаж, барилдаж чадаж байна. Би ч гэсэн чадна шүү дээ” гэсэн бодол төрж байсан. Одбаяр ах бас гоё барилдана. Тэр бүх барилдааныг харж, суралцаж, үлгэр дууриалал авдаг...

нэмчихээр буцаад уран нугарна гэдэг хэцүү юм билээ. Гар дээр тогтохоос эхлүүлээд. Дээрээс нь яс томтой, өндөр болж эхэлсэн болохоор биеэ даахаа больчихсон. Тэгээд л болчихоор нь шийдсэн. Гэтэл ээж маань нэг өдөр “Чи барилдах юм уу” гэж байна. Эхний удаа ч би нэг ач холбогдол өгөөгүй, яасан ч яахав гээд өнгөрсөн. Гэтэл ээж маань “Нугарч байгаад больчихсон, одоо аль ч үгүй үлдлээ” гээд болохоор тандаг хүн олонтой. Нэг өдөр “Алдар” спорт хороо руу залгаад, охиноо барилдуулья гэж дасгалжуулагчид нь хэлсэн юм билээ. Гэтэл 12 настай, арай жаахан байна, дараа жил ирээрий гэсэн. Тэр хооронд гэртээ суугаад, бүдүүн болчихдог юм байгаа биз дээ. Жил тойрон явж байгаад би өөрөө “Ээжээ барилдуулах юу болсон” гэж асуухгүй юу. Тэгтэл хөтөлж авч яваад, “Алдар” дээр очсон чинь эмэгтэй хүүхэд авахгүй гэж байна. Харин “Женко” клуб дээр оч, Цэвэлмаа гэж багш байгаа гээд зааж өгсөн. 2008 оны дөрөвдүгээр сард багш дээрээ

очоод, хичээллэж эхэлсэн. Анх очиход багш маань тэмцээн үз гээд л суулгачихсан. Би ч гайхаад, тэмцээн үзээд сууж байгаа юм чинь. Ойлогхгүй, баахан л барилддаг эгч нар л байсан. Ингэж барилддаг юм байна гэж бодож, үзэж суусан даа, тэр үед. Тэгээд долоо хоногийн дараа дүүргийн аваргад орсон. Тэр тэмцээнд ороод хүрэл медаль авсан. Яаж ч ялсан юм, ямар ч байсан медаль дээр буусан. Хүрэл медаль авчихаад ирсэн чинь ээж маань бөөн баяр, долоо хоног хичээллээд хүрэл авчихлаа гээд л. Дахиад долоо хоногийн дараа улсын аваргаас медаль аваагүй хүүхдүүдийн тэмцээн болсон. Орхон аймагт болсон юм. Тэнд очиж барилдаж, мөнгөн медаль авсан. Дахиад долоо хоногийн дараа дүүргийн аваргаар орж хүрэл авсан. Тэр бүхнээсээ урам аваад л жүдод дауласан даа. Нугардаг болохоор уян, унахгүй байсан юм билээ. Тэгж байгаад л нэг мэх хийнэ. Багш гар хавчиж эргэдэг нэг мэх заагаад өгчихсөн. Түүнийгээ л эхний хоёр жил хийж барилддаг байлаа даа.

-Есөн жил жүдо бөхөөр хичээллээд л дэлхийн медальтан боллоо доо?

-14 настайгаасаа хойш есөн жил хичээсний хүчинд бас нэг зорилгодоо хүрлээ. Дунд нь 2014 оны сүүлчээр бэртэл авсан. Хагалгаанд ороод жил барилдаагүй. Мөрний бэртэл авсан. Мөр их амархан мултарчихдаг болсон юм. Хоёр, гурван жил дараалд мөр мултарсан. Тэгээд л хагалгаанд ороод, жил завсарласан даа.

-Уран нугаралтаар хичээллэж байсны ач тус, нөлөө гэж байна биз. Арай унаа холтой ч гэдэг юм уу?

-Манай багш тэнцвэрийн тархи нь илүү хөгжсөн гэж хэлдэг юм. Уран нугаралтаар багаасаа хичээллэхээр чинь гар дээрээ тогтохоос авахуулаад тэнцвэр их авна. Тийм болохоор тэнцвэр сайтай. Магадгүй унаа холтой ч байж болох юм. Мэдээж бас уян. Уян болохоор гулжигнаад мэхэнд унахгүй байх талтай. Давуу тал гэвэл ийм л байна даа.

-Мэдээж энэ амжилтад хүрэхэд олон хүн тусалж дэмжсэн. Тэр хүмүүстээ хандаж хэлэх үг байгаа байх?

-Би чинь Төв аймгийн Баянхангай сумын харьяат гэж явдаг юм. Хэдийгээр Улаанбаатар хотод төрсөн ч гэсэн Төв аймагт харьяалагдаж яваа. Нутгийнхан маань тусалж, дэмждэг. Мэдээж “Женко” клубын хамт олон байна. Би чинь гавьяат дасгалжуулагч Шархүүгийн Цэвэлмаа багшийн удирдлага дор багаасаа л хичээллэсэн. Одоо шигшээ багт багтаж, Гавьяат дасгалжуулагч О.Балжинням, дасгалжуулагч Баттулга, Дашдаваа, Эрдэнэт-Од гээд олон сайхан багш нарын удирдлага дор бэлтгэлээ базаадаг. Дэлхийн аваргаас медаль авахад энэ олон багш нарын маань заавар зөвлөгөө маш их хэрэгтэй. Мөн бэлтгэл хангасан дүү нар маань байна. Тэр бүх хүмүүстээ баярлалаа гэж хэлье. Мөн гэр бүлийнхэндээ бүтхэд нь баярлалаа.

ЗАВСАРЛАГА

Улаанбаатарт:



Маргааш

Өдөр +16

Шөнө +3



Нөгөөдөр

Өдөр +18

Шөнө +6

Өдрийн зурхай

НАМРЫН ТЭРГҮҮН ШАР
БИЧ САРЫН
ТАВАН ШАР МЭНГЭТЭЙ
ХӨХӨГЧИН МОГОЙ ӨДӨР

Үс засуулбал:
Нүд бүрэлзэн улцайна.
Наран ургах, шингэх:
06.35-19.04



Тухайн өдөр үхэр, тахиа жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба гахай, хулгана жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштгэй. Эл өдөр хууль цааз гаргах, батлах, хэрэглэх, хулгай дээрмийг номхотгох, гэмтнийг шийтгэх, мал адгуус номхруулах, сүм дуганыг сэргээх, газар лусын зан үйл хийх, өр барагдуулах, гэр бүрэхэд сайн. Ургаа мод таслах, газрын ам нээх, гөлөг тэжээхэд муу. Өдрийн сайн цаг нь үхэр, луу, морь, хонь, нохой, гахай болой. Хол газар яваар одогсод баруун хойш мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулахад тохиромжгүй.



ИХ ГЭРИЙН ЭЗЭГТЭЙ

Үргэлжлэл.
Түрүүч нь №156 дугаарт

-Нэг эргүүлд хэдэн хүн байдаг вэ?
-Арваад хүн.
-Ийм том хаялгыг самнахад 10 хүн хангалтгүй.
-Ганц хүн байсан ч хангалттай. Түүнээс гадна тэдэнд нохой, зэр зэвсэг бий. Харуул манааныхан сохор, бид үл үзэгдэгч хүмүүс биш шүү дээ.
Олон нохойн дуу ойрхон сонсдож байлаа.
-Уучлаарай, Банда. Би чамайг уруу татаж энэ хөөтэй юманд оруулах ёсгүй байсан юм гэж Жемийг хэлэхэд
-Чи намайг уруу татсан юм байхгүй дээ гэв.
Бандагийн юу хэлэх гэснийг Жемн ойлгожээ... Тэдэнд хүний дуу сонсогдов. Жемн, Банда хоёр бага шиг элсэн довцогийн дэргэд очлоо.
-Элс ухаад нуугдвал яасан юм бэ?
-Тэгж үзсэн хүн цөөнгүй бий. Ноход дор нь олоод багалзуурыг нь тас хаздаг юм. Би зовохгүй түргэн үхэхийг хүснэ. Тэд намайг олж хараг. Дараа нь намайг зугтаж гүйхээр тэд буудаж эхэлнэ. Ноход тасчуулах хүсэл алга гэхэд нь Жемн Бандагийн гараас шүүрч аваад,
-Бид үхэх үйлтэй байж болох юм. Гэхдээ би л үхлээ утгаж гүйхгүй, чөтгөр алгад. Намайг алах гэж байгаа бол жаахан зүтгэг... гэв. Одоо тэр хоёрт хүний яриа тодхон сонсогдож байлаа. “Шалавлаарай, залхуу новшнууд аа. Цувраад яв. Та нар ханатал унтагцаасан. Одоо ажилдаа орцгоо” гэж нэг хүн хашгирч байв. Жемн өөрийн эрхгүй гэдэргээ хэд алхан эргэж тэнгис рүү харлаа. “Живж үхсэн бол дээр байж уу дээ” гэж тэр бодов. Шовх шовх үзүүртэй хад чулууг тэнгисийн долгион мөргөн зад үсэрч байх нь харагдана. Гэнэт долгионы цаана, тэртээ хол нэг юм харагдлаа. Энэ юу байж болохыг тэр ойлгосонгүй.
-Банда, тэр хараач...
-Энэ чинь манан байна. Долоо хоногт хоёр, гурван удаа ийм манан татдаг юм... гэж Банда хэллээ. Тэр хоёрыг ярьж байх зуур манан ойртон ирж, асар том хөшиг шиг юм бүхнийг халхаллаа. Хүний дуу



ч ойртож, энүүхэн хажууд нь сонсогдоно.
-Энэ мананг чөтгөр алгадаасай. Дахиад л саатах нь байна. Манай эзэд л дургүйцэнэ дээ.
-Энэ чинь бидний найдлага гэж Жемн шивнэв.
-Юун найдлага вэ?
-Манан. Эднүүс биднийг харахгүй.
-Ашиг алга. Нэгэн цагт манан арилж, бид эндээ үлдэнэ. Харуул манааныхан минат талбайгаар нэвтэрч чаддаггүй байхад бид бол бүр чадахгүй. Ийм манантайд хэдхэн алхаад дороо хэдэн хэсэг тасчуулна. Чи дахиад ид шидийн хүчинд найдаж байна.
-Тэглгүй яах вэ гэж Жемн хэлэв.
Тэнгэр харанхуйлж, манан тэнгисийг хэдийнэ халхлаад одоо эрэг өөд ахиж байлаа. Хар хэрэм мэт манан аймаар харагдах боловч Жемн “Энэ манан биднийг аварна” гэж баярлан бодлоо.
-Хөөе, та хоёр. Энд ямар үхсэнээ хийж яваа юм бэ? гэх дуу гэнэт сонсогдлоо. Жемн, Банда хоёр эргэж харав. Зуугаад футийн цаана, элсэн довцогийн орой дээр буу барьсан манааны хүн зогсож байлаа. Жемн тэнгис рүү харав. Манан түргэн ойртож байлаа.
-Хөөе, та хоёр наашаа хүрээд ирцгээ... гэж манааны хүн хашгираад буугаа тэдэн

рүү чиглүүлэв. Жемн хоёр гараа өргөөд
-Би хөлөө хугалчихсан. Явж чадахгүй байна гэж хашгирсанд
-Тэгвэл дороо зогсож бай. Би өөрөө очно... гэж манааны хүн хэлээд буугаа доош буулган тэр хоёр руу ойртож ирлээ. Жемн эргэж харвал манан бүр дэргэд нь ирсэн байлаа.
-Гүйгээрэй... гэж Жемн шивэгнээд тэнгис тийш эргэн гүйсэнд Банда хойноос нь гүйв.
-Зогс...
Буун дуу тасхийж, сүм нь тэр хоёрын хажуугийн элсийг пурхийлгэв. Хоёул харанхуй манан руу гүйсээр байлаа. Дахин буу дуугарч, дараа нь тэр хоёр манан дунд ууслаа. Хүйтэн манан ясанд нь хүртэл жиндүүлэн хайрав. Эргэн тойрон хөвөнд ороогдсон юм шиг юу ч харагдахгүй байлаа. Хойноос нь хөөж яваа хүмүүсийн дуу тал талаас нь сонсдоно.
-Крюгер ээ, би Брент байна. Чи сонсож байна уу?
-Сонсож байна, Крюгер.
-Цагаан, хар хоёр хүн эрэг дээр гарч ирсэн байна. Бүгдээрээ нааш хүрээд ир. Тэр хоёрыг шууд алаарай...
-Ойрхон байгаарай... гэж Жемн шивэгнэхэд Банда гараас нь шүүрч аваад,
-Одоо хаачих вэ?
-Эндээс явцгаая...
Жемн луужинг нүдэндээ

ойртуулан харахад зүү нь үзэгдэх төдий байлаа. Дорно зүг хаана байгааг арайхийн тодорхойлоод,
-Ийшээ гэв.
-Байзаарай. Бид нэвтэрч чадахгүй. Ноходтой харуул манааныхан тааралддаггүй юм аа гэхэд мина дээр орчихно.
-Минатай талбай хүртэл дахиад зуун ярд зай бий гэж чи хэлсэн шүү дээ. Бид эргээс холдох хэрэгтэй байна.
Тэр хоёр танихгүй мэдэхгүй газраар цөлийн зүг сохор таамгаар алгуурхан явлаа. Жемн алхаагаа тоолж байв. Хоёул байн байн ойчиж, бие биеэ түшин босгоод цааш явж байлаа. Хэдхэн фут яваад Жемн зогсож, луужингаар зүг чигээ шалгана. Зуугаад ярд яваад дороо зогслоо.
-Энэ хавиас минатай талбай эхэлнэ. Миньг онцгой аргаар тавьсан юм биш биз. Биднийг аврах ямар нэгэн зүйл байж болох биш үү?
-Залбирах л үлдэж дээ. Энэ минатай талбайгаар одоо болтол хэн ч нэвтэрч байгаагүй. Мина газар сайгүй бий. Зургаан ямхын гүнд зоосон байгаа. Бидэнд манан замхрахыг хүлээж байгаад харуул манааныханд бууж өгөх зам байна гэлээ.
Харанхуй манан дунд сонсдож буй хүмүүсийн дуут Жемн чагнав.
-Крюгер ээ, дуугараач...
-Би байна. Брент...

-Крюгер...
-Брент...
Зузаан хөвөн мэт манан дунд биегүй хоолой нэг нэгийгээ дуудаж байв. Жемн ухаандаа бүхий л хувилбарыг тооцоолон шаргуу бодож байлаа. Эндээ үлдэх юм бол манан арилмагц тэр хоёрыг даруй буудан ална. Минатай талбай руу явах юм бол мина тэсэрч хэдэн хэсэг тасчина.
-Чи тэр мина үзсэн үү?
-Би өөрөө булж байсан.
-Яаж тэсэрдэг юм бэ?
-Хүний биеийн жин дээрээс нь дарахаар тэсэрдэг. 80 фунтээс илүү жинтэй юм бүхэн тэсрэх оньсыг ажиллуулна. Тийм болохоор нохой дээгүүр нь явахад тэсэрдэггүй юм.
Жемн гүнзгий санаа алдаад,
-Банда, би эндээс гарах аргыг мэдэх юм шиг байна. Элсэн дээр биеийнхээ жинг жигд хуваарилах хэрэгтэй.
-Ай тэнгэр минь
-Чи юу бодож байна?
-Кейптаунаас явдаг би ямар тэнэг амьтан бэ? гэж бодож байна.
-Чи надтай хамт мөлхөхийг зөвшөөрөх үү?
Жемид хажууд нь зогсож буй Бандагийн царай бараг харагдахгүй байлаа.
-Надад голж шилтээд байх юм үгүй биз дээ, аан?
-Тэгвэл урагшаа...
Жемн элсэн дээр болгоомжтой сунайн хэвтэв. Банда түүнийг хараад нэг санаа алдан бас дагалаа. Хоёр эр элсэн дээгүүр минатай талбай тийш алгуурхан мөлхөв.
-Хөдлөхдөө гар хөлөөрөө газар битгий дараарай. Бүх биеэрээ хөдлөөрөй гэж Жемн хэлэв.
Банда хариу хэлсэнгүй. Амьд үлдэхсэн гэж хүсэхийн ихээр хүсч байлаа. Эргэн тойрон юу ч харагдахгүй хав харанхуй. Тэр хоёр хэдийд ч манааны хүн, нохой юм уу, минатай дайралдаж болох байв. Жемн энэ тухай бодохгүйг хичээнэ. Тэд туйлын удаан урагшилж байлаа. Тэр хоёр цамцгүй учир элс биеийг нь урна. Амьд мэнд гарах найдлага бараг байхгүйг Жемн ойлгож байв. Минатай талбайг амьд мөлхөн өнгөрч чадаад харуул манааныхантай дайралдахгүй өнгөрдөг юм аа гэхэд өмнө нь өргөст төмөр утас, буутай манаач хүлээж байгаа. Түүний дээр манан хэдийд арилах нь тодорхойгүй. Манан одоо ингээд ч замхарч магад. Тэр хоёр цагийн баримжааг бүрмөсөн алдаад урагшаа мөлхсөөр байв. Ямх нь фут, фут нь ярд, ярд нь миль болж хувирна. Тэнгисийн эргийг орхисноос хойш хэдий хэр хугацаа өнгөрснийг бүү мэд. Хоёр эр толгойгоо газарт наах хэрэг болж, нүд, хамар, чихэнд элс орно. Амьсгаа авахад хэцүү байлаа. Тэртээ хол “Крюгер... Брент... Крюгер... Брент” гэх дуу сулхан сонсогдоно. Тэр хоёр хэдэн минут тутамд амрах, луужингаар зүг чигээ шалгах гэж зогсож байлаа. Илүү түргэн мөлхөх дур хүсэл хэчнээн их байв. Энэ бол өвдөг тохойгоороо газар тулна гэсэн үг. Тэгээд төмрийн хэлтэрхий гэдэс рүү нь шигдэн орохыг мэдрэх шиг болно. Тийм болохоор яарахгүйг хичээж байлаа. Хүмүүсийн дуу сонсогдсоор байсан боловч манан дунд чухам аль талаас сонсдож байгааг ялгах арга байсангүй. “Элсэн цөл уужим билээ. Бид гараад явчихна” гэж Жемн горьдон бодов. Гэнэт манан дундаас нэгэн нохой гарч ирээд Жемийн дээрээс үсрэн буув...

Үргэлжлэл дараагийн дугаарт...



FROM THE TEAM THAT BROUGHT YOU THE **TAKEN** TRILOGY AND **THE EQUALIZER**

5 NAVY SEALS
\$300 MILLION IN GOLD
1 INCREDIBLE MISSION

RENEGADES

УДАХГҮЙ ДЭЛГЭЦНЭЭ

2017.09.15

2017.09.22

Colin Firth

Julianne Moore

Taron Egerton

Mark Strong

Halle Berry

Elton John

Channing Tatum

Jeff Bridges

Kingsman
THE GOLDEN CIRCLE
COMING SOON

ШИЛДЭГ КОНТЕНТИЙГ ТҮГЭЭГЧ ҮНДЭСНИЙ КОМПАНИ

төсөөллөөс илүүт тэнгисээс...